

МОНГОЛ УЛС ДАХ ХКОМ-ЫН ТОЙМ

Ver. 3.0 (2018 оны 12 сар)



БАЙГАЛЬ ОРЧИН
УУР АМЬСГАЛЫН САН



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Ministry of the Environment

IGES
Institute for Global
Environmental Strategies



АНГЛИ ХЭЛ ДЭЭР ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН АРЯНИЕ АМЕЛЛИНА
УУР АМЬСГАЛ, ЭРЧИМ ХҮЧНИЙ АЛБА, ДАЯН ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ХЭЛ ДЭЭР ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН Л.ОТГОНЦЭЦЭГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН САН

Энэхүү баримт бичиг нь Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ын талаар дэлгэрэнгүй, ойлгоход хялбар аргаар тайлбарласан мэдээллийг өгөх зорилготой. Энэ баримт бичиг нь олон улсын хэлэлцээрт тохиролцсоны дагуу бүх текстийг яг тэр хэлбэрээр нь хуулбарлахгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Мөн, дэлгэрэнгүй тайлбар болон үйл явцын талаар олон улсын хэлэлцээрт хараахан эцэслэн шийдвэрлэгдээгүй асуудлууд байгаа. Текстүүдийн дэлгэрэнгүй агуулга, тохирсон тодорхойлолтуудыг ХКОМ-ын вэбхуудсан дээр <https://www.icm.go.jp> байгаа холбогдох бичиг баримтаас үзнэ үү.

Энэхүү баримт бичигтэй холбоотой асууж лавлах зүйл байвал ce-info@iges.or.jp э-шуудангаар холбогдоно үү.

ЕРӨНХИЙ АГУУЛГА

Товчилсон үгийн хураангуй

Баримт бичгийн тайлбар

1. Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)

1-1. Хоёр талын баримт бичиг x1

1-2. ХКОМ-ын тухай x2

2. ХКОМ-ын төслийн үе шат x3

3. ХКОМ-ын холбоотой байгууллагууд

3-1. Японы улсын Засгийн газар – Монгол улсын Засгийн газар x5

3-2. ХКОМ-ын Хамтарсан Хороо x6

3-3. Хамтарсан Хорооны дэмжлэг үзүүлэх бүтэц x8

3-4. Гуравдагч талын этгээд (ГТЭ) x9

3-5. Төсөлд оролцогчид (ТО) x12

3-6. Харилцааны арга хэлбэр (ХаХ) x12

4. ХКОМ-ын төслийн аргачлал

4-1. Аргачлалын бүтэц x14

4-2. Ялгаралын үзүүлэлт x15

4-3. Төсөлд оролцох шалгуур x16

4-4. Аргачлал боловсруулах x17

4-5. Санал болгосон аргачлалыг танилцуулах журам x18

4-6. Батлагдсан аргачлалд шалгалт хийх журам x20

5. Төслийн баримт бичгийг боловсруулах

5-1. ТББ-ийг боловсруулах x21

5-2. Мониторинг хийх төлөвлөгөө x22

5-3. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө боловсруулах x23

6. Төсөлд бүртгүүлэх

6-1. Магадлагаанд тавигдах шаардлага x24

6-2. ТББ-ийг нийтлэх x26

6-3. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг илгээх, хянах x27

6-4. Төсөлд бүртгүүлэх хүсэлт гаргах журам x28

7. Бүртгэлийн дараах үе шат

7-1. ХКОМ-д бүртгэгдсэн төсөлд өөрчлөлт оруулах x29

7-2. Бүртгэгдсэн ХаХ-ийн төсөлд өөрчлөлт оруулах x30

8. Кредит олгох

8-1. Нотолгоонд тавигдах шаардлага x31

8-2. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайланд үнэлгээ хийх x32

8-3. Кредит олгох хүсэлтийн өмнөх журам x33

9. Төслөөс татгалзах

9-1. Төслөөс татгалзах хүсэлт гаргах журам x34

Тайлбар x35

Асуулт, хариултууд x36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ХУРААНГУЙ/ЕРӨНХИЙ НЭР ТОМЬЁО

ХүХ	ХҮЛЭМЖИЙН ХИЙ
ХХ	ХАМТАРСАН ХОРОО
ХКОМ	ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМ
ХаХ	ХАРИЛЦААНЫ АРГА ХЭЛБЭР
ТҮШ	ТӨСЛИЙН ҮЕ ШАТ
ТББ	ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ
ТО	ТӨСӨЛД ОРОЛЦОГЧИД
ТХТө	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
ТХТа	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙН ТАЙЛАН
ГТЭ	ГУРАВДАГЧ ТАЛЫН ЭТГЭЭД
НҮБУАӨСК	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУУРЬ КОНВЕНЦИ
МН	МАГАДЛАГАА, НОТОЛГОО

ХАВСРАЛТ БИЧИГ БАРИМТУУД/НЭМЭЛТ

ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЧИГ, БАРИМТЫН ДҮРЭМ, ЖУРМЫН ТАЙЛБАР	МАЯГТУУД
ЕРӨНХИЙ	<ul style="list-style-type: none"> Монгол, Япон улсын Засгийн газар хоорондын Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл (2013) Талуудын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах (2016) ХКОМ-ын төсөл хэрэгжүүлэх журам ХКОМ-ын төслийн нэр томъёоны тайлбар ХКОМ-ын Бүртгэлийн системийн тодорхойлолт 	
ХАМТАРСАН ХОРОО	Хамтарсан Хорооны дүрэм, журмууд	
ТӨСЛИЙН ЖУРАМ	ХКОМ-ын төслийн үе шат	
АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРУУЛАХ	Санал болгосон аргачлалыг боловсруулах зааварчилгаа	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын санал болгосон төслийн аргачлалын маягт ХКОМ-ын санал болгосон аргачлалын ажлын хүснэгт ХКОМ-ын батлагдсан аргачлалд шалгалт хийх маягт
ТББ БОЛОВСРУУЛАХ	ТББ болон Мониторингийн тайлан боловсруулах зааварчилгаа	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын ТББ-ын маягт ХКОМ-ын Харилцааны арга хэлбэрийн мэдэгдэх хуудас
Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайлан бичиг баримтыг боловсруулах	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайлан боловсруулах зааварчилгаа	<ul style="list-style-type: none"> Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөний маягт Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлангийн маягт
МОНИТОРИНГ	ХКОМ-ын төслийн үе шат	<ul style="list-style-type: none"> Мониторингийн төлөвлөгөөний хуудас Мониторингийн бүрэлдхүүний хуудас Мониторингийн тайлангын хуудас
ГТЭ, МАГАДЛАГАА БА НОТОЛГОО	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын төслийн ХМН хийх байгууллагыг томилох зааварчилгаа ХКОМ-ын төслийн Магадлагаа ба Нотолгоо хийх зааварчилгаа 	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын төслийн ХМН хийх байгууллагыг томилох өргөдлийн маягт ХКОМ-ын Магадлагааны тайлан боловсруулах маягт ХКОМ-ын Нотолгооны тайлан боловсруулах маягт
ТӨСЛИЙГ БҮРТГЭХ	ХКОМ-ын төслийн үе шатны журам	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын төслийг бүртгүүлэх хүсэлт гаргах маягт ХКОМ-ын төслөөр бүртгэсний дараах өөрчлөлт хийхийг хүссэн маягт ХКОМ-ын төслөөр бүртгэгдхээс татгалзах хүсэлтийг тавих маягт ХКОМ-ын төслөөс татгалзах хүсэлтийг тавих маягт
КРЕДИТ ОЛГОХ	ХКОМ-ын төслийн үе шат	<ul style="list-style-type: none"> ХКОМ-ын кредит олгохыг хүссэн өргөдлийн маягт ХКОМ-ын кредит олгохоос татгалзсан маягт

1-1. Хоёр талын хамтын ажиллагааны баримт бичиг

- ◆ Монгол улс, Япон улсын Засгийн газар хооронд “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” байгуулах тухай баримт бичигт 2013 оны 1 сарын 8-ны өдөр гарын үсэг зурсан.
- ◆ Монгол улс нүүрстөрөгч багатай хөгжилд хүрэхийн тулд нүүрстөрөгч бага ялгаруулах технологи, бүтээгдэхүүн, тогтолцоо, үйлчилгээ, болон дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор ХКОМ-ыг хэрэгжүүлнэ. [Doc, para 3]
- ◆ ХКОМ-ын хүрээнд хүлэмжийн хийг бууруулах төслүүдийг хэрэгжүүлснээр баталгаажсан бууралт эсвэл шингээлт нь тухайн улс орны олон улсын түвшинд хүлэмжийн хийг бууруулах хувь нэмэрт нь тооцогдох юм. [Doc., para 5]
- ◆ Талууд аргагүй боловсруулах, ХКОМ-ын хүрээнд байгаль орчны бүрэн бүтэн, ил тод байдлыг ханган ажиллаж, ХКОМ-ыг энгийн, ашиглаж болохуйц, дэлхийн хүлэмжийн хийн ялгаралын бууралтыг дэмжих хүртэл цогц арга хэмжээ авч ажиллахыг дэмжинэ [Doc., para 6]
- ◆ ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн, технологийн, чадавхийг бэхжүүлэх дэмжлэгийг аль аль талууд үзүүлэн нягт хамтарч ажиллана. [Doc., para 8]
- ◆ ХКОМ нь үл худалдаалагдах кредит олгох төрлийн механизм хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна. [Doc., para 9]
- ◆ Энэ түншлэл нь Конвенцийн хүрээнд хэрэгжих боломж бүхий олон улсын шинэ гэрээ хэлэлцээр хүчин төгөлдөр болох хүртэл буюу 2030 он хүртэл хугацаанд үргэлжилнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-ийн хэлэлцээрт гарсан ахиц дэвшлийг харгалзан үзэж хоёр тал энэхүү хамтын ажиллагааны боломжит сунгах хугацааг харилцан тохиролцон дуусгавар болохоос нь өмнө шийдвэрт хүрнэ. [Modification of the Bilateral Document Rol ver 3 , para 43]

ХүХ гэдэг нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), метан (CH₄), азотын дутуу исэл (N₂O), ус фторт нүүрстөрөгч (HFCs), перфторт нүүрстөрөгч (PFCs), 6 фторт хүхэр (SF₆), 3 фторт азот (NF₃) тэдгээр хий юм. [Rol ver.4, para 2]

НҮБ-ийн Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд 2015 оны хэлэлцээрт оруулах Япон улс үндэсний зорилтот хувь нэмэр (INDC)-тээ ХүХ-н ялгаралаа 2013 онтой харьцуулахад 2030 он гэхэд 26,0%-аар бууруулна гэсэн үүрэг амлалт авсан. ((2005 оны санхүүгийн жилтэй харьцуулахад 25,4%-р буурсан) (2030 он гэхэд ойролцоогоор 1.042 тэрбум тн CO₂-той тэнцэх хэмжээний ялгаралыг бууруулна)). Түүнчлэн эрчим хүчний хосолсон байдлаа хадгалж , улсын хэмжээнд хүрч болохуйц зорилтыг тодорхойлон цогц бодлогоор дэмжиж, бие даасан технологиудыг дэмжинэ.

- ХКОМ нь Япон улсын хүлэмжийн хийн ялгаралын бууралтын зорилтод тусгагдсан тооцоололд багтахгүй, гэхдээ ХКОМ-ын хүрээнд Япон улсын дэмжлэгтэйгээр бусад улсын бууруулсан ялгаралын бууралт нь Япон улсын бууралтын хэмжээнд тооцогдоно.
- Хувийн хэвшилд суурилсан төслүүдийн хувь нэмрээс гадна ХКОМ-ын хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын дэмжиж буй нийт ялгаралын бууралт/шингээлт нь 2030 оны санхүүгийн жил гэхэд 50 -100 сая тн-CO₂ байна гэж одоогоор тооцоолсон байна. [GoJ Jul 2018]

1-2. ХКОМ-ын ерөнхий зарчим

ХКОМ-ын зорилго [RoI ver.4, para 1]:

- ☞ Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, эсвэл тэдгээрийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх боломжтой төслүүдийг Монгол улсад хэрэгжүүлж, Японы хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр өндөр хөгжилтэй орнуудын байгальд ээлтэй, хүлэмжийн хий бага ялгаруулдаг техник, технологи, ажил үйлчилгээ, бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ;
- ☞ Хөгжиж буй улсад хэрэгжүүлж буй хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах буюу шингээж буй бодит хэмжээг тоон утгаар тооцоолж баталгаажуулах, энэ хувь хэмжээг хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн, олон улсын гэрээ хэлэлцээгээр хүлэмжийн хийн ялгаралаа бууруулах үүрэг хүлээсэн хөгжилтэй оронд энэ үүргээ биелүүлэхэд нь ашиглах;
- ☞ Хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах буюу шингээлтийг нэмэгдүүлэх замаар дэлхий дахины хүчин чармайлт болон НҮБ-ын суурь конвенцийн эцсийн зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах

- ☞ ХКОМ нь үл худалдаалагдах кредит олгох төрлийн механизм хэлбэрээр үйл ажиллагаагаа эхэлнэ. Хоёр тал худалдаалагдах боломжтой кредит олгох төрлийн механизмд шилжих талаар зөвшилцөлийг үргэлжлүүлэх бөгөөд ХКОМ-ын хэрэгжилтийг харгалзан үзэж, энэхүү зөвшилцөлийг аль болох эрт үр дүнд хүргэх талаар ажиллана. [RoI ver.4, para 4]
- ☞ ХКОМ нь худалдаалагдах боломжтой кредит олгох төрлийн механизмд шилжсэний дараа хөгжиж буй орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтад ХКОМ-оор дамжуулан бодит хувь нэмэр оруулахыг зорино. [Doc., para 10]
- ☞ Талууд олгосон болон ашиглагдаж байгаа кредитийн статусаа давхар тоологдоогүй байх тал дээр анхаарна. [RoI ver.4, para 41]
- ☞ Талууд ХКОМ-ын хэрэгжилтийн ил тод байдлыг хангах тал дээр шаардлагатай арга хэмжээг авна. [RoI ver.4, para 15]

Диаграм: Монгол-Японы ХКОМ-ын схем



Боломжит хугацаа ба үе шат	Оролцогч талууд	Үйл ажиллагаа	Үр дүн (бичиг баримтууд)
(0) Аргачлалыг боловсруулах	<ul style="list-style-type: none"> ◆ TO ◆ XX 	<ul style="list-style-type: none"> ◆ Төсөлд оролцогчид (ТО) болон талууд аргачлалын төслийг бэлтгэн Хамтарсан Хороонд(ХХ) хүргүүлнэ. Хүргүүлсэн төслийн аргачлалын бүрэн гүйцэд байдлыг шалгасны дараа олон нийтийн саналыг тусгана. Дараа нь ХХ төслийг батлах эсвэл цуцлах шийдвэрээ гаргана. [RoI ver.4, para 20-21, PCP ver.6 para 6] <ul style="list-style-type: none"> ☞ Санал болгосон аргачлалыг танилцуулах албан ёсны журам байдаг. (chap. 4 of this CHARTS) 	<ol style="list-style-type: none"> 1. Санал болгосон аргачлал 2. Санал болгосон аргачлалын ажлын хүснэгт
(1) Төслийн баримт бичиг (ТББ), ТХТө боловсруулах	<ul style="list-style-type: none"> ◆ TO ◆ XX 	<ul style="list-style-type: none"> ◆ ХКОМ-ын төслийн үйл ажиллагаанд зориулж Төсөлд Оролцогч талууд төслийн бичиг баримт (ТББ) болон ТХТө-г боловсруулна. (chap. 5 of this CHARTS), Төслийн бичиг баримтыг "ХКОМ-ын төслийн бичиг баримтын маягт" ба мониторингийн төлөвлөгөөтэй хамт илгээнэ. [PCP ver.6, para 30] <ul style="list-style-type: none"> ☞ ТББ нь төслийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой техникийн болон бүтцийн талаарх мэдээлэл болон төслийн батлагдсан аргачлал гэх зэрэг мэдээллийг агуулсан байна. ☞ ТХТө-ний бичиг баримт нь ХКОМ-ын төслүүдийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулах дэлгэрэнгүй төлөвлөгөө байна. /урьдчилан тооцоолох үнэлгээ/ 	<ol style="list-style-type: none"> 1. ТББ ба Мониторингийн ажлын хүснэгт 2. Харилцааны арга хэлбэр 3. ТХТө
(2) Магадлагаа	<ul style="list-style-type: none"> ◆ ГТЭ ◆ TO ◆ XX 	<p>Баталгаажуулалт нь ТББ дээр үндэслэн ХХ-оос боловсруулсан магадлагааны журмын эсрэг ГТЭ байгууллагын санал болгосон ХКОМ-ын төслийн бие даасан үнэлгээний үйл явц юм. [RoI ver.4, para 24]</p> <ul style="list-style-type: none"> ◆ ТХТө-ний бичиг баримтыг нарийн бичгийн газар хянана. Сөрөг үр дагавар илрээгүй эсвэл авах арга хэмжээнийн төлөвлөгөөг тодорхой тусгасан бичиг баримтыг гүйцэд гэж үзнэ. ✓ Магадлагаа хийх албан ёсны журам байдаг. (chap. 6 of this CHARTS) 	<p>Магадлагааны тайлан</p>
(3) Бүртгэл	<ul style="list-style-type: none"> ◆ XX 	<ul style="list-style-type: none"> ◆ Бүртгэл нь ХКОМ-ын төсөл мөн болохыг ХХ-оос албан ёсоор баталгаажуулсан зөвшөөрөл юм. [RoI ver.4, para 27] <ul style="list-style-type: none"> ☞ Төслөөр бүртгүүлэхийг хүссэн албан ёсны журам байдаг. (chap.6) ◆ Хэрэв бүртгэгдсэн ТББ-д тусгагдсан төслийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарвал ТО талууд тухайн өөрчлөлтийг ХХ-д хүсэлтээр мэдэгдэнэ. (chap.4 of this CHARTS) 	<p>Төслийн хувийн дугаар</p>

2. ХКОМ-ын төслийн үе шат

Үе шат	Оролцогч талууд	Үйл ажиллагаа	Үр дүн (бичиг баримтууд)
(4) ХКОМ-ын төслийн үйл явцад мониторинг хийх	◆ ТО	<ul style="list-style-type: none"> ❖ Төсөлд оролцогч тал нь ТББ-д тулгуурлан ХКОМ-ын төслийн ХүХ-н ялгаралын бууралт буюу шингээлтэнд хяналт тавих замаар ХКОМ-ын төслийг хэрэгжүүлнэ. [RoI ver.4, para 30] Мониторингийн төлөвлөгөөг сайжруулж болно. ❖ Төсөлд оролцогч тал мониторингийн тайлангаа бэлдэн Хөндлөнгийн магадлагаа-нотолгоо хийгч байгууллагаар шалгуулах хүсэлт гаргана. [RoI ver.4, para 32] 	<i>Мониторингийн тайлан</i>
(5) Нотолгоо болон ТХТа-д хийх үнэлгээ	◆ ГТЭ ◆ ТО ◆ ХХ	<ul style="list-style-type: none"> ❖ Нотолгоо нь бие даасан тодорхой хугацааг хамарсан, шүүмж дүгнэлт бөгөөд нотолгоо хийх явцад ГТЭ-ээр тогтоогдсон ХКОМ-ын төслийн мониторинг хийсэн ялгаралын бууралт/шингээлтийн үр дүн. [RoI ver.4, para 31] ❖ ТХТа-ийн үнэлгээний бичиг баримтыг ХХ-оор хянана. Сөрөг үр дагавар илрээгүй эсвэл үнэлгээний явцад гарсан сөрөг үр дагаварт залруулах арга хэмжээ авсан бол зөвшөөрөгдсөн гэж үзнэ. <ul style="list-style-type: none"> ☞ Нотолгоо хийх болон ТХТа-ийн албан ёсны журам байдаг. (chap. 8 of this CHARTS) 	<i>Нотолгооны тайлан, ТХТа</i>
(6) Кредит олгох	◆ ТО ◆ ХХ	<ul style="list-style-type: none"> ❖ ТО тал нь ТО талуудын кредит хуваах тухай дурдсан нотолгооны тайланд суурилсан нээсэн хаягаараа дамжуулан ХХ-нд 2 талд кредит олгох талаар мэдэгдэнэ. ХХ гаргасан хүсэлтийн бүрэн гүйцэд байдлыг шалгаж тал тус бүрт үр дүнг мэдэгдэнэ. [RoI ver.4, para 36-37] <ul style="list-style-type: none"> ☞ Кредит олгох албан ёсны журам байдаг. (chap. 4 of this CHARTS) 	<i>Бүртгэгдсэн кредитийн сериал дугаар</i>
(7) Кредитээ ашиглах	Талууд	<ul style="list-style-type: none"> ❖ Тал тус бүрт олгогдсон кредитийг хоёр талын хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах зорилтоо биелүүлэхэд ашиглаж болно. [RoI ver.4, para 40] 	<i>(талуудын бодлогоос хамаарна)</i>

Тайлбар: ХКОМ-ын төслийн үе шат (ТҮШ) хувилбар 05.0 [PCP ver.6]

☞ Энэ процедур нь ТО тал, ГТЭ болон ХХ, Нарийн бичгийн газрын дагаж мөрдөх ёстой ХКОМ-ын төслийн аргачлал батлах, бүртгэл болон кредит олгох зэрэг аль аль талд хамааралтай захиргааны үе шатыг тайлбарласан болно.

3-1. Япон улсын Засгийн газар-Монгол улсын Засгийн газар

◆ Хоёр тал [Doc., para 2-11]:

- ☞ Бүсийн болон 2 талын хамтын ажиллагааны хүрээнд НҮБ-ийн бага нүүрстөрөгч бүхий хөгжлийн төлөө бодлого, олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэх
- ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхийн тулд хоёр тал ХХ байгуулан ажиллана.
- ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн, технологийн болон чадавхыг бэхжүүлэх шаардлагатай дэмжлэг туслалцааг аван нягт хамтран ажиллана.
- ☞ ХКОМ-ыг хэрэгжилтийн явцад талууд худалдаалагдах боломжтой кредит олгох төрлийн механизмд шилжих талаар үргэлжлүүлэн аль болох цаг алдалгүйгээр зөвлөлдөн дүгнэлтэд хүрнэ
- ☞ ХКОМ нь худалдаалагдах боломжтой кредит олгох төрлийн механизмд шилжсэний дараа хөгжиж буй орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтад ХКОМ-оор дамжуулан бодит хувь нэмэр оруулахыг зорино.
- ☞ ХКОМ-ын бодлоготой холбогдолтой хэлэлцүүлгийг ХХ-ны хурлын үеэр зохион байгуулна. [RoI ver.4, para 11]

◆ Тал тус бүр [RoI ver.4, para 13-17]

- ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд ХХ-оос дүрэм журмыг боловсруулахдаа тухайн улс орны холбогдох дотоодын хууль тогтоомж, дүрэм журамд үндэслэн боловсруулна:
 - a) Урьдчилсан байдлаар аргачлалын төслийг бэлтгэн Хамтарсан Хороонд (ХХ) хүргүүлнэ;
 - b) ХХ-оос боловсруулсан бүртгэлийн нийтлэг үзүүлэлтүүдийн дагуу бүртгэлийн системийг үүсгэн хөтлөх;
 - c) ХХ-оос кредит олгох тухай мэдэгдэлд үндэслэн бүртгэлийн системд олгогдсон кредитийн хэмжээг бүртгэнэ. /төсөлд оролцогч талд хуваасан кредитийг оруулах/
- ☞ ХКОМ-ын хүрээнд олгогдсон кредитийг ХХ-д яаралтай мэдэгдэнэ.
- ☞ ХКОМ-ын хэрэгжилтийн ил тод байдлыг хангах тал дээр шаардлагатай арга хэмжээг авна.
- ☞ ХХ-оос томилсон холбогдох талын гишүүн солигдох тохиолдолд нөгөө талын ХХ-нд өөрчлөлтийг бичгээр мэдэгдэнэ. [RoP ver.2, para 5]
- ❖ Талууд давхар тоологдохоос сэргийлэх зорилгоор ХКОМ-ын хүрээнд бүртгэгдэн хэрэгжиж байгаа уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төслүүдийг бусад энэ чиглэлийн олон улсын механизмд хамруулахгүй. Талууд олгосон болон ашиглагдаж байгаа кредитийн статусаа давхар тоологдоогүй байх тал дээр анхаарна. [Doc., para 7, RoI ver.4 para 16, 40-41]
- ❖ ХКОМ-ын хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн схемийн талаар Японы тал Монголын талд тухайн санхүүжилт эхэлсэн даруйд мэдэгдэнэ. [RoI ver 4, para 17]

Тайлбар: Японы Засгийн газрын дэмжлэг (2018 оны санхүүгийн жилд) [GoJ Jul 2018] [<https://www.jbic.go.jp/ja/efforts/jcm>]

Санхүүгийн дэмжлэг

- ХКОМ-ын Загвар төсөл болон JCM REDD+загвар төсөл болон ЖАЙКА-ийн туслалцаатай хэрэгжүүлэх төслүүд болон бусад засгийн газрын хамааралтай санхүүжилтийн институт
 - АХБ итгэлцлийн сан (ХКОМ-ын Японы сан)
 - ХКОМ-ын үзүүлэх төсөл
 - ХКОМ-ын тусгай санхүүжилтийн схем (JSF)

Чадавх бэхжүүлэх

Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа

3-2. ХКОМ-ын Хамтарсан Хороо (ХХ)

[Doc., para 4, RoI ver.34 para 5-12, 22-23]

◆ ХХ-нь Японы улсын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газрын төлөөллүүдээс бүрдэнэ.

◆ ХХ-ны үндсэн үүргүүд:

- ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмуудыг боловсруулах, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах болон шингээлтийн аргачлалын хэмжээг тооцоолох, гуравдагч хөндлөнгийн байгууллагыг томилох болон бусад ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай захиргааны холбогдолтой асуудлыг шийдвэрлэнэ.
- ☞ ГТЭ-ийг томилох, цуцлах, түдгэлзүүлэх
- ☞ Төсөлд оролцогч талаас ирүүлсэн ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх хүсэлт дээр үндэслэн, ГТЭ-ээр баталгаажсан төслийг ХКОМ-ын төслөөр бүртгэнэ.
- ☞ Төсөлд оролцогч талаас ирүүлсэн кредит олгохыг хүссэн өргөдөл болон ГТЭ-ээр нотлогдсон тайлан дээр үндэслэн Хамтарсан Хороо кредитийг олгон талуудад мэдэгдэнэ.
- ☞ ХКОМ-ын хэрэгжилтийн талаарх тайланг боловсруулан, ХКОМ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, менежменттэй холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхийн тулд нарийн бичгийн газрыг байгуулан ажиллана.

ХХ-ны гишүүдийн үүрэг [RoP ver.2, para 5-8]

- ☞ Хамтарсан хороо нь тал тус бүрээс томилогдсон 10 хүртэлх тооны гишүүдээс бүрдэнэ.
- ☞ ХХ-ны гишүүд нь урьдчилан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр зөвшөөрөгдсөн тооны дотор нэмэгдэж, хасагдаж, өөрчлөгдөж болно.
- ☞ ХХ-ны гишүүд нь ямар ч тохиолдолд хувийн болон санхүүгийн шууд ашиг сонирхолтой байх ёсгүй
- ☞ ХХ-нь талуудыг төлөөлөн сонгогдсон 2 даргатай байх ба Монголын талаас томилогдсон болон Японы талаас томилогдсон даргыг тус тус мэдэгдэнэ. Хэрвээ аль нэг талын дарга солигдвол, тухайн тал нь түүнийг орлох даргыг томилно.
- ☞ ХХ-ны дарга нар тал тус бүрийн ХХ-ны гишүүдийн үүрэг гүйцэтгэгчийг томилж болно. Ийм томилгоог бичгээр эсвэл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

3-2. ХКОМ - Хамтарсан Хороо (ХХ)

Хурал [RoP ver.2, para 11-17]

❖ Хурлын хуваарь:

- ☞ ХХ- нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
- ☞ Нарийн бичгийн газар нь ХХ-ны даргатай зөвшилцсөний үндсэн дээр хурал болохоос хоёр долоо хоногийн өмнө хурлын товыг мэдэгдэнэ.
- ☞ Нарийн бичгийн газар нь ХХ-ны дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр хурлын хөтөлбөрийг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө, хурлын бичиг баримтуудыг эцсийн байдлаар хурал болохоос өмнөх ажлын 5 өдрөөс хэтрүүлэхгүйгээр бэлтгэнэ.

❖ Хурлын шийдвэр:

- ☞ ХХ-нь хурлын шийдвэрийг харилцан зөвшилцөн батална.
- ☞ ХХ-ны дарга нар харилцан зөвшилцөлд хүрсэн эсэхийг бататгана. ХХ-ны дарга нар ХХ-ны гишүүдээс санал болгосон шийдвэрт ямар нэг татгалзсан хариу аваагүй бол харилцан зөвшилцсөнийг зарлана.

❖ Хурлын ирц

- ☞ Холбогдох талын ХХ-ны гишүүдийн орлох гишүүн нь ХХ-ны хуралд гишүүний үүргийг гүйцэтгэн оролцож болно. Орлох гишүүнийг хурлын өмнө бичгээр эсвэл цахим хэлбэрээр мэдэгдсэн байна.
- ☞ ХХ-ны хурал нь ХХ-оос гаргасан шийдвэрээс бусад тохиолдолд 2 талын зөвшөөрөлтэйгөөр хөндлөнгийн ажиглагчдад нээлттэй байна.

Цахим хэлбэр болон утсаар гаргасан шийдвэр гэдэг нь: [RoP ver.2, para 18-20]

- ☞ ХХ-оос цахим хэлбэрээр гаргасан шийдвэрүүд нь дараах дүрэм журмыг баримталсан байна.
- ☞ (a) ХХ-ны дарга нараас ХХ-ны бүх гишүүд рүү цахим хэлбэрээр явуулсан санал болгосон шийдвэр
 - (b) (I) ХХ-ны дарга нар цахим хэлбэрээр баталсан мэдэгдэлд ХХ-ны аль нэг гишүүнээс цахим хэлбэрээр санал болгосон шийдвэрийг илгээснээс хойш 10 хоногийн дотор татгалзсан хариу ирээгүй, эсвэл (II) ХХ-ны бүх гишүүд цахим хэлбэрээр баталсан тохиолдолд санал болгосон шийдвэрийг зөвшөөрөгдсөн гэж үзнэ.
- ☞ ХХ-ны аль нэг гишүүнээс татгалзсан хариу ирсэн тохиолдолд ХХ-ны дарга нэр гишүүний саналыг харгалзан үзэж зохих арга хэмжээг авна.
- ☞ ХХ шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжихийн тулд утсаар холбогдох хурлыг зарлаж болно.

[RoP ver.2, para 26-27]

- ☞ ХХ-ны гишүүд, нарийн бичгийн газар болон ХХ-ны үйл ажиллагааг төлөөлж буй бусад байгууллага болон хүмүүс тус тусын ажилд хүндэтгэл үзүүлэн өөрт хамааралтай бүх мэдээллийн нүүцлалыг гуравдагч этгээдэд задруулах болон зүй бусаар ашиглаж болохгүй.
- ☞ ХХ-оос гаргасан бүх шийдвэрийг шийдвэр гарсны дараа нэн даруй бүрэн эхээр нь олон нийтэд ил болгоно.

3-3. ХХ-нд дэмжлэг үзүүлэх бүтэц

[RoP ver.2, para 23-25]

- ◆ Нарийн бичгийн газар
 - ☞ ХКОМ-ыг хэрэгжүүлэхийн тулд ХХ хоёр талын нарийн бичгийн газрыг ажилуулна. [RoI ver.4, para 12]
 - ☞ ХХ-оор сонгогдсон нарийн бичгийн газар нь ХХ-ны шаардсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- ◆ Гадаад тусламж
 - ☞ ХХ ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хүмүүсийг ажиллуулж болно. Мэргэжилтний багийн ажиллах дүрэм журмыг ХХ шийднэ.
 - ☞ ХХ гаднаас мэргэжилтнүүдийг ажил үүргээ гүйцэтгэхдээ туслуулан авч ажиллуулах шийдвэрийг гаргаж болно.

ХКОМ-ын ХХ-нд дэмжлэг үзүүлэх бүтэц [\[https://www.jcm.go.jp/mn-jp/jc_members\]](https://www.jcm.go.jp/mn-jp/jc_members)

Япон улсын талаас

Монгол улсын талаас

ХКОМ-ын Хамтарсан Хорооны (ХХ)-ны гишүүд

- Монгол улс дахь Японы элчин сайдын яам (2 гишүүн)
- Гадаад хэргийн яам
- Эдийн засаг, Худалдаа, Аж үйлдвэрийн яам
- Байгаль орчны яам

- Байгаль орчин, Аялал жуулчлалын яам
- Эрчим Хүчний Зохицуулах хороо
- Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам
- Барилга, Хот байгуулалтын яам
- Зам тээврийн яам
- Эрчим хүчний яам
- Гадаад хэргийн яам
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар

Нарийн бичгийн газар

Mitsubishi UFJ Research and Consulting Co., Ltd.

БОАЖЯ-ны харьяа Байгаль Орчин, Уур Амьсгалын Сан

3-4. Гуравдагч Талын Этгээд (ГТЭ)

- ◆ ХХ-оос томилогдсон Гуравдагч талын этгээд нь: [RoI ver.4, para 18, 22-23]
 - (a) ТО талаас гаргасан хүсэлт дээр үндэслэн ХХ-оос боловсруулсан магадлагаа хийх зааварчилгааны дагуу ТО талын бэлтгэсэн ТББ-д заасны дагуу төслийг баталгаажуулан ТО талд баталгаажуулалтын үр дүнг мэдээлэх;
 - (b) ТО талаас гаргасан хүсэлт дээр үндэслэн ХХ-оос боловсруулсан ХҮХ-н ялгаралын бүүралт буюу шингээлтийн нотолгоо хийх зааварчилгааны дагуу ТО талын бэлтгэсэн мониторингийн тайланд тусгагдсан ХКОМ-ын төслийн хүрээнд амжилттайгаар бүүруулсан буюу шингээсэн ХҮХ-н ялгаралыг баталгаажуулан нотолгооны тайландаа нотолгооны үр дүнгээ баримтжуулан илгээнэ.
- ◆ ГТЭ-аар томилогдохыг хүссэн хуулийн этгээдийн анкетыг хүлээн авсны дараа ГТЭ хийх байгууллагаар томилох дүрэм журмын дагуу Хамтарсан Хороо ГТЭ болох байгууллагыг томилон, томилогдсон ГТЭ-ийн холбогдох мэдээллийг ХКОМ-ын вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. [for the list of TPEs: <https://www.jcm.go.jp/mn-jp/tpes>]
- ◆ Хамтарсан Хороо нь ГТЭ-ийн томилгоог гэмт хэрэгт холбогдох, залилан хийх, эсвэл аж ахуйн нэгжийн чадамжгүй болсон тохиолдолд түдгэлзүүлэн цуцалж болно.

ГТЭ байгууллагыг томилоход тавигдах шаардлага [GL TPE ver.4, para 10-11]

ГТЭ байгууллагаар томилогдох хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байх:

- ◆ Хүсэлт гаргагч этгээд нь:
 - ☞ Олон улсын итгэмжлэлийн форум (IAF) эсвэл ISO 14064-2 дээр суурилсан (цаашид "PAC" гэх), Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны магадлан итгэмжлэлийн гишүүн байгууллагаас ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж, эсвэл
 - ☞ Цэвэр хөгжлийн механизмын (CDM) Гүйцэтгэх зөвлөлөөр итгэмжлэгдсэн үйл ажиллагааны этгээдээр Томилогдсон эрх бүхий байгууллага (ТЭБ) байна.
- ◆ Хүсэлт гаргагч этгээд нь ХКОМ-ын холбогдох дүрэм, журмуудыг уншиж танилцан Монгол-Японы Хамтарсан Кредит Олгох Механизмын талаар хангалттай мэдлэгтэй байна.

Хамрах хүрээ [GL TPE ver.4 para 12, 14, 17]

- ◆ Хамтарсан Хороо нь ХКОМ-ын хамрах салбарын хүрээнд хүсэлт гаргагч этгээдийг томилохдоо дараах зарчмуудыг баримтална:
 - (a) Олон улсын ISO 14065 хүрээнд өргөдлийн маягтад дурдсан магадлагаа, нотолгоо хийх чадавхи бүхий салбаруудын дагуу итгэмжлэгдсэн тохиолдолд; мөн
 - (b) Өргөдөл гаргагч этгээд нь Цэвэр Хөгжлийн Механизмын хүрээнд итгэмжлэгдсэн/томилогдсон этгээд байх бөгөөд ЦХМ-ын хамрах салбаруудтай дүйцсэн эсвэл Хамтарсан хороогоор хэлэлцэж шийдсэн байх
- ◆ ХКОМ-ын төслийн хамрах хүрээг Хавсралт 1-д дурдсан болно. [of GL TPE ver.4].
- ◆ ГТЭ байгууллага нь ХКОМ-ын дүрэм журмын дагуу нэмэлт салбарын хамрах хүрээнд томилогдохыг хүсэхдээ тухайн салбарын хамрагдаж болохоор хүрээг олон томилогдох өргөдлөө явуулна.

ГТЭ байгууллагыг томилох журам [GL TPE ver.4 para, 13-16, 18]

- ◆ Хүсэлт гаргагч этгээд ХХ-руу өргөдлийн маягтаа илгээнэ.
- ◆ Нарийн бичгийн газар өргөдлийн маягтын бүрэн гүйцэд байдлыг шалган хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хүсэлт гаргагч этгээд рүү холбогдон хариу өгнө.
- ◆ ХХ нь өргөдлийг бүрэн гэж үзэж байгаа бол хүсэлт гаргагч этгээдийг ГТЭ-аар томилох эсвэл өргөдлийг түдгэлзүүлэх эсэхээ шийднэ.
- ◆ Нарийн бичгийн газар хүсэлт гаргагч этгээд рүү өмнөх шийдвэрийн хариуг мэдэгдэх ба ХКОМ-ын вэбхуудсаар дамжуулан томилдогдсон ГТЭ байгууллагын хамрах хүрээ болон холбогдолтой мэдээллийг олон нийтэд ил болгоно.

3-4. Гуравдагч Талын Этгээд (ГТЭ)

Томилгоог түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эрхийг сэргээх [GL TPE ver.4, para 20]

◆ Томилгоог дараах нөхцөлд түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгоно:

- XX-ны хянаж үзсэнээр ХКОМ-ын холбогдох дүрэм журам нь тухайн ГТЭ-д хамаарахгүй гэсэн шийдвэрийг ХХ гаргасан тохиолдолд;
- ГТЭ байгууллагын олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн эсвэл ЦХМ-ын хүрээнд итгэмжлэгдсэн/томилогдсон статус нь өөрчлөгдсөнтэй холбоотойгоор;
- ГТЭ байгууллага ХКОМ-ын төслийн хүрээнд томилогдсон статусаасаа сайн дурын үндсэн дээр түдгэлзүүлвэл;

a. Дараах журмын дагуу хүчингүй болгох эсвэл түдгэлзүүлнэ. [GL TPE ver.4, para 21-22]

- ◆ ХХ нь ГТЭ байгууллагад ХКОМ-ын холбогдох дүрэм, журмыг дагаж мөрдөж байгаа эсэх дээр хяналт тавьж болно. Энэ хяналтыг ГТЭ-ийн гүйцэтгэл дээр үндэслэн газар дээр нь очиж хянаж болно. ХХ нь хяналттай холбоотой ажлын хэсгийг гүйцэтгүүлэхээр гадны мэргэжилтэн эсвэл байгууллагыг томилон ажиллуулах шийдвэрийг гаргаж болно.
- ◆ Хэрэв ХХ нь ГТЭ байгууллагыг ХХ-оос гаргасан холбогдох дүрэм, журмыг мөрдөхгүй байгааг хяналтаар олж илрүүлвэл ХХ-ны зүгээс ГТЭ-ийн зарим болон бүх салбарын хамрах хүрээний томилгоог хүчингүй болгох эсвэл түдгэлзүүлэх шийдвэрийг ГТЭ-ийг сонсох боломжийг олгосны дараа гаргана. ХХ-оос авсан хүчингүй болгох, түдгэлзүүлэх шийдвэрийг тэр өдрөөс нэн даруй хэрэгжүүлж эхэлнэ.

b. ГТЭ байгууллагын олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн эсвэл ЦХМ-ын хүрээнд итгэмжлэгдсэн/томилогдсон статус нь өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хүчингүй болгох, түдгэлзүүлэх журам [GL TPE ver.4, para 23-26]

- ◆ Зөвхөн олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн ГТЭ байгууллагын хувьд, ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн салбарын зарим эсвэл бүх хамрах хүрээ нь хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн, ХКОМ-ын төслийн хүрээнд харгалзах салбарын хамрах хүрээний ГТЭ байгууллагын томилгоог хүчингүй болгох эсвэл түдгэлзсэнийг хүчингүй болгосон түдгэлзүүлсэн тэр өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ. Олон улсын ISO 14065 хүрээнд "Салбарын зарим хамрах хүрээг түдгэлзүүлэх" гэдгийг "хамрах хүрээг бууруулах" гэж тайлбарласан байдаг.
- ◆ Зөвхөн ЦХМ-ын хүрээнд томилогдсон ГТЭ байгууллагын хувьд итгэмжлэгдсэн/томилогдсон тэмдэглэгээ нь салбарын зарим болон бүх хамрах хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн, ХКОМ-ын төслийн хүрээнд харгалзах салбарын хамрах хүрээний ГТЭ байгууллагын томилгоог хүчингүй болгох эсвэл түдгэлзсэнийг хүчингүй болгосон түдгэлзүүлсэн тэр өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ.
- ◆ Олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн ЦХМ-ын дагуу томилогдсон ГТЭ байгууллагын хувьд:
 - Олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн эсвэл ЦХМ-ын хүрээнд итгэмжлэгдсэн/томилогдсон салбарын зарим болон бүх хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн аль нь ч бай ХКОМ-ын дагуу зохих салбарын хамрах хүрээнд хүчингүй болгосон эсвэл түдгэлзүүлсэн ГТЭ байгууллагын томилгоог дор дурдсан (b)(c) дэд хэсгүүдэд тайлбарласан нөхцөлүүдээс бусад үед хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн өдрөөс эхлэнэ.
 - Олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн ГТЭ байгууллага нь сайн дурын үндсэн дээр түдгэлзсэн эсвэл ЦХМ-ын хүрээнд итгэмжлэгдсэн ГТЭ байгууллагын салбарын зарим болон бүх хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн аль нь ч бай ХКОМ-ын хүрээнд томилогдсон ГТЭ байгууллагын томилгоог хүчингүй болгохгүйгээр ГТЭ байгууллагын бусад хөтөлбөрийн хүрээнд томилогдсон эсвэл итгэмжлэгдсэн тухайн салбарын хамрах хүрээг хэвээр нь үргэлжлүүлж болно, мөн
 - Олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн ГТЭ байгууллага нь сайн дурын үндсэн дээр түдгэлзсэн эсвэл ЦХМ-ын хүрээнд итгэмжлэгдсэн ГТЭ байгууллагын салбарын зарим болон бүх хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн аль нь ч бай ХКОМ-ын хүрээнд тухайн салбарын зарим болон бүх хамрах хүрээнд одоогийн байдлаар хүчингүй болгосон байгаа ГТЭ байгууллагын томилгоог ХХ-оос түдгэлзүүлэх эсвэл эргэн томилох шийдвэрийг гартал хүчингүй болгоно.



ГТЭ байгууллагын нөхцөл байдал өмнө тайлбарласан шалтгааны дагуу өөрчлөгдвөл ГТЭ байгууллага цаг алдалгүйгээр ХХ-д мэдэгдэнэ.

3-4. Гуравдагч Талын Этгээд (ГТЭ)

Хүчингүй болгох, түдгэлзүүлэхтэй холбогдох үйл явц [GL TPE ver.4, para 30-34]

- ◆ Томилогдсон ГТЭ-ийн салбарын зарим болон бүх хамрах хүрээ нь хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн үед ХХ-нь ГТЭ-ийн хүчингүй болгосон эсвэл түдгэлзүүлсэн шалтгааны талаар ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нэн даруй мэдэгдэнэ.
- ◆ Томилогдсон ГТЭ-ийн зарим болон бүх хамрах хүрээг хүчингүй болгосон эсвэл түдгэлзүүлсэн тохиолдолд ГТЭ нь ХКОМ-ын гэрээний дагуу хийгдэж байгаа магадлагаа эсвэл нотолгоо хийх үйл ажиллагааг хүчингүй эсвэл түдгэлзүүлсэн даруйд ТО тал зэрэг ГТЭ-тэй холбоотой ажилладаг бүх байгууллагуудад мэдэгдэнэ.
- ◆ Томилогдсон ГТЭ-ийг хүчингүй болгосон тохиолдолд ГТЭ нь ХКОМ-ын гэрээний дагуу хийгдэж байгаа гэрээг цуцлах үед хүчин төгөлдөр байсан магадлагаа эсвэл нотолгоо хийх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийж болно.
- ◆ Томилогдсон ГТЭ-ийн салбарын зарим болон бүх хамрах хүрээг түдгэлзүүлсэн тохиолдолд, ГТЭ нь ХКОМ-ын төслийн түдгэлзүүлсэн хамрах хүрээний магадлагаа эсвэл нотолгоо хийх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийх боломжгүй.
- ◆ ГТЭ-ээр нэгэнт баталгаажуулж, эсвэл нотлогдсон төсөл нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэрт нөлөөлөхгүй ч гэсэн ХХ-оос энэ төсөл дээр ямар нэгэн арга хэмжээ авч болно.

Томилогдсон эрхийг эргэн сэргээх журам [GL TPE ver.4, para 35-39]

- ◆ Томилогдсон эрх нь салбарын зарим болон бүх хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэнээс хойш ХХ-ноос ГТЭ-д хийсэн шалгалтаар ХКОМ-ын холбогдох дүрэм журамд дахин харшлахгүй болсон ГТЭ нь хүчингүй болгосон шалтгаанаа залруулан тайлбарласан баримт бичгийг томилогдох эрхээ сэргээхийг хүссэн өргөдлийн маягттай хамт илгээсэн байна.
- ◆ Олон улсын ISO 14065 хүрээнд итгэмжлэгдсэн эсвэл ЦХМ-ын дагуу томилогдсон нөхцлийг хангахгүй болсноос хойш томилогдсон эрх нь салбарын зарим болон бүх хамрах хүрээнд хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн ГТЭ нь олон улсын ISO 14065 хүрээнд эсвэл ЦХМ-ын дагуу итгэмжлэл нь сэргээгдсэн эсвэл хүчингүй болсныг цуцалсны дараа томилогдох эрхээ сэргээхийг хүссэн өргөдлийн маягтаа илгээнэ.
- ◆ ГТЭ-ийн томилогдох эрх нь сэргээгдсэн тохиолдолд нарийн бичгийн газар ГТЭ-ийн талаар болон сэргээгдсэн салбарын хамрах хүрээг ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нэн даруй мэдээлнэ.
- ◆ ХХ-нь хүчингүй болсон эсвэл түдгэлзүүлсэн ГТЭ-ийн томилгоог илгээсэн баримт бичиг дээр нь үндэслэн томилгоог сэргээх эсэх талаар шийдвэр гаргана.

ГТЭ сайн дурын үндсэн дээр төслөөс түдгэлзэх

[GL TPE ver.4, para 27-29]

- ◆ ГТЭ томилгоогоо салбарын зарим болон бүх хамрах хүрээнд түдгэлзүүлэх байр сууриа ГТЭ-ийн нэр, ГТЭ-ийн татгалзах хүсэлтэй салбарын хамрах хүрээ, ГТЭ-ийн томилгоогоо түдгэлзүүлэхийг хүссэн өдөр зэргийг дурдан цахим хэлбэрээр захиа бичин илгээнэ.
- ◆ ГТЭ-ийн томилгоог салбарын зарим эсвэл бүх хамрах хүрээнд сайн дураар түдгэлзүүлэх хүсэлт гаргасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- ◆ ГТЭ сайн дурын үндсэн дээр түдгэлзсэн хэдий ч энэ нь ГТЭ-ийн сайн дураар түдгэлзэхээс өмнө хийсэн санхүүгийн холбоотой үнэлгээ гэх зэрэг асуудалтай холбоотой гэрээгээр байгуулсан үүрэг, үйл ажиллагаа зэрэгт нөлөөлж тухайн ажлаас чөлөөлөхгүй.

Тайлбар: ХКОМ-ын Магадлагаа ба Нотолгоо хийх зааварчилгаа хувилбар 1.0 (МН Зааварчилгаа) [GL VV ver.1]

☞ Энэхүү зааварчилгаа нь ТО талтай байгуулсан гэрээ хэлцэлийн дагуу ХХ-оос баталсан ХКОМ-ын аргачлал дээр үндэслэн ХКОМ-ын төслийн магадлагаа ба нотолгоог хийх ГТЭ -д хамаарна.

Тайлбар: ХКОМ-ын Гуравдагч Талын Этгээдийг томилох зааварчилгаа. хувилбар 1.0 [GL TPE ver.4]

☞ Энэхүү зааварчилгаа нь хүсэлт гаргагч этгээд, ГТЭ, ХХ болон нарийн бичгийн газар, ГТЭ-ийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, томилох зэрэгт хамаарна.

3-5. Төсөл хэрэгжүүлэгч тал (ТО)

◆ Төсөл хэрэгжүүлэгч талууд: [RoI ver.4, para 19]

- ☞ Аргачлалын төслийг бэлтгэн ХХ-оор батлуулахаар хүргүүлэх
- ☞ ТББ-ийг бэлтгэн ГТЭ байгууллагаар магадлагаа хийлгэхээр хүргүүлснийг ХХ-руу мэдэгдэх
- ☞ ГТЭ байгууллагаар магадлагдсан ТББ-ийг бүртгүүлэхээр ХХ-руу хүргүүлэх
- ☞ ТББ-ийн дагуу мониторинг хийлгэн ХКОМ-ын төслийг хэрэгжүүлэх
- ☞ Мониторингийн тайлангаа бэлтгэн ГТЭ байгууллагаар нотолгоо хийлгэхээр илгээх
- ☞ ХКОМ-ын хүрээнд тал тус бүр дээр кредит олгохыг хүссэн өргөдөл болон ГТЭ байгууллагаар шалгагдсан нотолгооны тайлангаа ХХ-руу хүргүүлэх

3-6. Харилцааны арга хэлбэр (ХаХ)

ХаХ-ийн үе шат [PCP ver.6, para 39-41, 45]

- ◆ ХКОМ-ын төслийн ТО тал өөрсдийн өмнөөс ХХ болон нарийн бичгийн газартай эрх бүхий байгууллагын хүрээнд холбогдон ажиллах төлөөлөгчийг томилох ба ХаХ-ийн бичиг баримтанд энэхүү мэдээллээ оруулж өгнө.
- ◆ ХКОМ-ын санал болгосон төслийн ХаХ-ийг мэдүүлсний дараа ХХ, нарийн бичгийн газар болон ТО талууд эсвэл тухайн төслийн талуудын албан ёсны харилцаа холбоо нь төлөөлөгчөөр дамжуулан явагдана.
- ◆ ТО тал "ХКОМ-ын Харилцааны арга хэлбэрийн маягт" (ХаХ маягт)-ны сүүлийн хувилбарыг ашиглан ТББ-ийг ХХ-д хүргүүлэн олон нийтийн саналыг авах болон ГТЭ байгууллагад магадлагаа хийлгэхээр мэдүүлэх үедээ ХаХ-ээ ХХ болон ГТЭ байгууллагад мэдүүлнэ. ХаХ-ийн маягтанд төлөөлөгчийн болон бусад ТО талын холбоо барих мэдээллийг оруулна.
- ◆ Нарийн бичгийн газар ХКОМ-ын вэбхуудсанд ХаХ-ийн маягтыг төслийг бүртгэгдсэний дараа нийтлэнэ. ХаХ-ийг зөвхөн ТО талууд болон ХКОМ-ын төсөлд хамааралтай ХХ, нарийн бичгийн газар, ГТЭ байгууллагын дунд хуваалцана. Нарийн бичгийн газар төслийн ХаХ-ийн 1-4 дэх хэсгийг төлөөлөгчийн гарын үсгийн загваргүйгээр олон нийтэд хүргэж болно.

Төслийн төлөөлөгч [PCP ver.6, para 42-44]

- ◆ ТО нь төслийн төлөөлөгчид дараах эрхүүдийг олгоно:
 - (а) Тусгай заасан хаягаар кредит олгох тухай хүсэлт гаргахтай холбоотойгоор холбоо тогтоох;
 - (б) ТО тал сайн дураар төсөлд оролцохоос түдгэлзэх болон төлөөлөгчөө солих түүнчлэн байгууллагын нэр, эрхзүйн статус, холбоо барих мэдээлэл, гарын үсгийн загварыг өөрчлөх хүсэлтэй холбоотой харилцаа;
 - (в) (а) болон (б) хэсгүүдэд дурдагдаагүй төсөлтэй холбоотой бусад асуудлаар харилцах;
- ◆ ТО тал болон төслийн төлөөлөгч нар үндсэн болон орлох этгээдийн итгэмжлэгдсэн гарын үсэгтэй байна. ТО болон төслийн төлөөлөгчийн заавар удирдамжаар итгэмжлэгдсэн гарын үсэг орлон зурах этгээд нь шаардлага хангасан байна.
- ◆ ТО тал ХаХ-тээ хувийн гэрээний зохицуулалтыг дурдах болон оруулахгүй.

Бүртгэгдсэн харилцааны арга хэлбэрт өөрчлөлт оруулах [PCP ver.6, para 110-118]

- ◆ ТО талууд батлагдсан харилцааны арга хэлбэрийн агуулгад өөрчлөлт гаргах хүсэлтээ ХКОМ-ын нарийн бичгийн газар руу мэдэгдэнэ.
- ◆ Мэдүүлсэн ХаХ-ийн бичиг баримтанд ХКОМ-ын дүрэм журамд үл нийцсэн, алдаатай зөрчил байгааг олж илрүүлсэн даруйд нарийн бичгийн газраас ХаХ-ийн шинэ мэдүүлэгийг шаардана.
- ◆ ТО тал ХаХ-ийн мэдүүлгийн өмнөх хувилбар /form/ маягтыг ХаХ-ийн шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор ашиглаж болно. Нарийн бичгийн газар шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дараа илгээсэн өмнөх хувилбарын баримт бичгийг хүлээн авахгүй.
- ◆ ХаХ-ын мэдүүлгийг мэдүүлж буй ТО эсвэл Төслийн төлөөлөгч нь дараах зүйлсийг анхаарна.

(а) Өмгөөлөгчийн эрх мэдлийг илтгэсэн баримт эсвэл удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, компаний нөхөрлөлийг баримтжуулсан бичгүүд эсвэл тухайн компанид улсаас олгож баталгаажуулж бүртгэсэн гэрчилгээ гэх зэрэг цахим байдлаар баталгаажуулах боломжгүй дагалдуулах бичиг баримтуудыг бүртгэгдсэн ХаХ-т өөрчлөлт оруулах хүсэлт мэдүүлж буй үеэс хойш 2 жил хүчинтэй байх хугацаатайгаар нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай. Дээрх заасан хугацаа нь иргэн, хувь хүний баримт бичигт хамаарахгүй;

(b) Нэгээс дээш ХКОМ-ын төсөл эсвэл ижил ХКОМ-ын төсөлд оруулах хэд хэдэн өөрчлөлт байгаа бол нэг маягтаар мэдүүлж болно.

- ◆ Төсөлд оролцогч талын төлөөлөл болсон хуулийн этгээд нь холбогдох эрх бүхий гарын үсэг зурах албан ёсны этгээд болон орлогч этгээд нь гарын үсэг зурах боломжгүй болсон тохиолдолд тэдний нэрийн өмнөөс гарын үсэг зурж болно. ТО талын нэрийн өмнөөс гарын үсэг зурсан хуулийн этгээд нь тухайн байгууллагын нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрхтэй гэж бичсэн нотолгоог ирүүлнэ.
- ◆ Хэрэв хавсаргасан баримт нотолгоо нь хангалттай бус байвал нарийн бичгийн газраас нэмэлт тайлбар/баримтыг шаардана.
- ◆ Нарийн бичгийн газраас ХКОМ-ын цахим хуудас дээрх хүчинтэй байгаа огноо болон шинэчилсэн ХаХ-ийг шаардлагатай бол хавсралт 1-ийн хамт нийтэлнэ.

Төслийн төлөөлөгчид өөрчлөлт оруулах [PCP ver.6, para 119-120]

- ◆ Бүртгэгдсэн ХКОМ-ын төслийн ТО тал нь төслийн төлөөлөгчийн томилгоонд шалтгаан, хугацаа харгалзахгүйгээр бүх ТО нарын гарын үсгээр баталгаажсан шинэ ХаХ-ийг мэдүүлэх, төслийн төлөөлөгч эвсэл ТО нарын аль нэгээр нь шууд дамжуулан өөрчлөлт оруулж болно.
- ◆ ТО тал нь төслийн төлөөлөгчид өөрчлөлт орсон тухайгаа ХаХ-ийн өмнөх хувилбарын маягтыг шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор ашиглаж болох ба түүнээс дээш хугацаанд өмнөх хувилбарыг нарийн бичгийн газар хүлээн авах боломжгүй.

ТО талд өөрчлөлт оруулах [PCP ver.6, para 121-122]

- ◆ Төсөл бүртгэгдсний дараа ХКОМ-ын төслийн ТО-д өөрчлөлт гарвал дор дурдсан өөрчлөлтүүд тутамд ХаХ-ын хавсралт 1-р маягтийг бөглөн мэдүүлнэ:
 - (a) ТО нэмэгдэхэд;
 - (b) Холбогдох байгууллагын нэр/статуст өөрчлөлт ороход;
 - (c) ТО нэрээ татахад; Хэрэв ТО төлбөрийн чадваргүйн улмаас дампуурч эсвэл бусад шалтгаанаар үйл ажиллагааг зогсоож ХаХ-ийн бичиг баримтанд ямар нэг байдлаар гарын үсэг зурах чадамжгүй болсон тохиолдолд баримтжуулсан нотолгоо бүхий мэдүүлгийг саатуулах.
 - (d) Зөвхөн холбоо барих мэдээлэл болон гарын үсгийн хувьд өөрчлөлт орж буй тохиолдолд.
- ◆ ХКОМ-ын төсөлд нэмэгдэн орж буй ТО нь ХаХ-ийн шинэчилсэн хувилбарыг зэрэг мэдүүлэх үед ХаХ-ийн одоо байгаа хувилбарыг хүлээн зөвшөөрөх

4-1. Аргазүйн бүтэц

◆ ХКОМ-ын төслийн мониторинг, ХКОМ-ын төсөл тус бүрийн ХүХ-н ялгаралын бууралтын тооцооллыг хийхэд аргазүйг ашигладаг.

Санал болгож буй аргазүй гэдэг нь:

- ☞ ХХ-гоор батлуулахаар мэдүүлсэн аргазүй
- ☞ Санал болгож буй аргазүйн маягт болон санал болгож буй аргазүйн хүснэгт

Санал болгож буй аргазүйн хүснэгт нь:

- ☞ Тоон мэдээг оруулах замаар ХүХ-н ялгаралын бууралтыг шууд тооцоолон гаргаж ирэх боломжтой мониторингийн төлөвлөгөө юм.
- ☞ Тоон мэдээг оруулах хуудас болон тооцооллын явцын хуудаснаас бүрдэнэ.

Тоон мэдээг оруулах хуудас

Энэ хуудсанд ТО-ын талаас өөрчлөлт оруулж болох жишиг үтгүүд болон төсөлд ашиглах тусгай параметрууд багтана. (жиш: түүхэн өгөгдлүүд)
 Параметр бүрд аргазүй боловсруулагч нар нь орсон өгөгдлүүдээс бусад шаардлагатай бүх нүдийг бөглөнө.

Тооцооллын явцын хуудас

ТО-ын зүгээс өөрчлөлт оруулах боломжгүй бүх жишиг үтгүүд, суурь ялгарал болон төслийн ялгаралыг гаргах тооцооллын үйл явц болон ялгаралын бууралтын үр дүн юм.

Батлагдсан аргазүй нь:

- ☞ ХКОМ-ын төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд ХХ-оор хэлэлцүүлэн батлуулсан аргазүйг хэлнэ.
- ☞ Энэ аргазүй нь батлагдсан аргазүйн баримт бичгүүд болон Мониторингийн хүснэгтээс бүрдэнэ.

Мониторингийн хүснэгт нь:

- ☞ Мониторингийн хүснэгт нь Мониторингийн төлөвлөгөөний хуудас, Мониторингийн бүтцийн хуудас, Мониторингийн тайлангийн хуудас зэргүүдээс бүрдэнэ.

Мониторингийн төлөвлөгөөний хуудас

нь урьдчилсан байдлаар ялгаралын бууралтын тооцоолол болон мониторингийн төлөвлөгөөний магадлагаа хийхээс өмнө ашиглагдана.

Мониторингийн бүтцийн хуудас

Мониторинг хийхийн тулд менежментийн болон үйл ажиллагааг явуулах бүтцийг бий болгоход зориулан магадлагаа хийхээс өмнө ашиглана.

Мониторингийн тайлангийн хуудас

Төслийн дараах ялгаралын бууралтын тооцоолол болон мониторингийн тайланг боловсруулахаар нотолгоо хийгдэхээс өмнө ашиглах хуудас.

- ☞ Мониторингийн Төлөвлөгөөний хуудас болон Мониторингийн Тайлангийн хуудас нь Санал болгож буй аргазүйн хүснэгт дээр үндэслэн бэлтгэсэн мэдээ оруулах хуудас, тооцооллын явцын хуудаснаас бүрдэнэ. ХХ-гоор санал болгосон аргазүй батлагдсаны дараа Мониторингийн Бүтцийн хуудсыг нарийн бичгийн газар нэмж оруулна.

Тайлбар: ХКОМ-ын санал болгож буй төслийн аргазүйг боловсруулах журам (Аргазүйн журам) [GL PM ver.2]

- ☞ Эдгээр журмуудад зориулагдсан ХКОМ-ын хүрээнд санал болгож буй аргазүйг боловсруулан ХХ-оор хэлэлцүүлэн батлуулахад бүх талуудад зориулагдсан.

4-2. Суурь ялгарал


[GL PM ver.2, para 7-8, Glos ver.1, No.6-7]

◆ ХКОМ-ын хүрээнд олгогдох хүлэмжийн хийн ялгаралын бууралтын кредитийг суурь ялгарал болон төслийн хүлэмжийн хийн ялгаралын хэмжээний зөрүүгээр тодорхойлно.

◆ Суурь ялгарал гэдэг нь


- ☞ Доор үзүүлсэн суурь сценарийн ялгаралын тооцоолол нь Монгол улсын хэмжээнд санал болгосон ХКОМ-ын төслийн энгийн үйл ажиллагааны үеийн болон ижил бүтээмжтэй байх үеийн хүлэмжийн хийн үнэмшилтэй ялгаралыг илэрхийлэх юм. (Хүлэмжийн хийн ялгаралд тооцогдохгүй байх нөхцөл болон нийт бууралтыг тодорхойлохын тулд)
- ☞ Нийт гарцтай харьцуулахад нэгж гарцад ногдож буй Хүлэмжийн хийн ялгаралыг нэгж кредитийн босгоор үржүүлсэн хэмжээгээр илэрхийлнэ.
- ☞ Кредитийн босго гэдэг нь төсөл хэрэгжүүлэгч орны хувьд ижил төрлийн төсөл хэрэгжүүлэхэд аргазүйд нь зориулан урьдчилсан байдлаар хэрэглэж болохуйц нийт бүтээмжийн нэгж бүрт харьцуулагдах ХүХ ялгарал гэх ойлголтоор тодорхойлогдоно. Энэ ойлголт нь уламжлалт байдлаар хадгалагдана.

Зураг: Суурь сценарийн ялгарал, суурь ялгарал болон төслийн ХүХ-н ялгаралын хоорондын хамаарлыг харуулсан зураг



Тайлбар: Нийт бууралтыг олж мэдэх өөр арга зам [GoJ Jul 2018]

- ☞ Жинхэнэ тоон утгыг тооцоололдоо хэмжиж ашиглах нь төслийн ялгаруулж буй ХүХ-н үнэн тоо хэмжээг хэд дахин илүүгээр тооцоолон гаргах эрсдэлтэй тул төслийн ялгаралын хэмжээг тооцоолохдоо уламжлалт хэмжээсийг ашиглах нь зүйтэй.



4-3. Шалгуур үзүүлэлтүүд

[GL PM ver.2, para 9, Glos ver.1, No.4]

- ◆ Шалгуур үзүүлэлтүүд гэдэг нь ХКОМ-ын аргазүйд тусгаснаар ХКОМ-ын төсөлд тавигдах шаардлагууд бөгөөд дараах агуулгатай:
 - (a) ХКОМ-ын төслөөр бүртгүүлэхийн тулд биелүүлэх шаардлагууд
 - (b) Батлагдсан аргазүйг ашиглахад төслүүдэд тавигдах шаардлагууд.

Тайлбар: Шалгуур үзүүлэлтүүд [GoJ Jul 2018]

- ◆ Шалгуур үзүүлэлт;
 - ☞ Төсөлд оролцогчдын өргөн мэдүүлснээр тухайн төсөл нь буцаагдах эрсдэлүүд багатай гэдгээ аргазүйдээ тодорхой тусгасан байх.
 - ☞ “Шалгах жагсаалт” нь ХКОМ-ын хүрээнд тухайн төсөл нь шалгуурыг хангаж байгаа эсэх, ХКОМ-ын аргазүйд нь тохирох эсэхийг хялбар аргаар тодорхойлох боломжийг олгодог.
 - ☞ Хоёр талын Засгийн Газар нь ХХ-гоор ХКОМ-ын аргазүйг батлах үйл явцаар дамжуулан шалгуур үзүүлэлтүүдэд ямар төрлийн технологи, бүтээгдэхүүн гэх зэрэг зүйлс багтахыг тодорхойлдог.
 - ☞ Төсөлд оролцогч нь ХКОМ-ын төслөөр төслөө бүртгүүлэх хүсэлт гаргах үедээ ХКОМ-ын хүрээнд батлагдсан жагсаалт бүхий аргазүйг ашиглаж болно.

◆ Жишээ нь:

(a) ХКОМ-ын төслөөр бүртгүүлэхэд тавигдах шаардлага.

- ☞ Санал болгож буй төслийн бүртгэл болон магадлагааны үнэлгээг үндэслэнэ.
- ☞ Жишээ нь:
 - ✓ Танилцуулж байгаа хх(бүтээгдэхүүн/технологи)-ийн дизайны үр ашиг нь хх (жиш: гарц/кВт)-ээс дээгүүр байна. <Benchmark Approach>
 - ✓ хх(инвертертэй агааржуулагч, цахилгаан тээврийн хэрэгсэл эсвэл нарны панел нь хураагууртай хосолсон мэтийн тусгай өндөр үр ашигтай бүтээгдэхүүн/технологууд)-ийн танилцуулга <Positive List Approach>

(b) Батлагдсан аргазүйд мэдүүлэг өгөх боломжтой төсөлд тавигдах шаардлага

- ☞ Жишээ нь:
 - ✓ х жилийн турш хэмнэсэн түүхэн тоон өгөгдлүүд байгаа эсэх
 - ✓ Сүлжээнд холбогдсон хх (жиш: нарны зай болон салхин турбин) жилийн цахилгаан үйлдвэрлэл
 - ✓ Одоо байгаа зуухыг сайжруулан боловсронгуй болгосон байдал
- ☞ ЦХМ-ын хүрээнд байдаг “аргазүйг хэрэгжүүлэх боломжит нөхцөл” гэдэгтэй ижил

4-4. Аргазүй боловсруулах

[GL PM ver.2, para 13, 15, 17-18] [PCP ver.6, para 6]

- ◆ Санал болгож байгаа арга зүй нь шалгуур үзүүлэлт, жишиг утгууд болон суурь ялгаралыг тогтоох талаархи логик болон тоон таамаглалыг баталгаажуулах баримт бичгийг дэмжиж өгдөг.
- ◆ Аргазүй боловсруулагч нь Японы тал, Монголын тал эсвэл ТО тал байх боломжтой.
- ◆ Санал болгож буй аргазүй гэдэг нь:
 - ☞ Аргазүйг төсөлд шууд ашиглах, гуравдагч талын этгээдээр дамжуулан ахин өөрчлөлт оруулах боломжтой, ашиглахад тодорхой, гаргацтайгаар үйл явцын талаар тайлбарлах;
 - ☞ Тухайн аргазүйг ашигласнаар цаашид ХКОМ-ын магадлагаа, нотолгоо хийх боломжийг бий болгох;
 - ☞ Бүх алгоритм, томъёонууд нь төслийг магадлах аргазүйг ашиглахад шаардагдах ба алхам алхмаар гүйцэтгэх боломжтой үйл явцуудыг тусгаж өгсөн байх. жиш: төслийн ялгарал, суурь ялгаралыг тооцоолон олох;
 - ☞ Аргазүйд тухайлан дурдагдаагүй дурын логикийн эсвэл тоо хэмжээний талаарх урьдчилсан таамаглалыг хийх удирдамжийг бий болгох бөгөөд аргазүйг ашиглаж буй хүн уг удирдамжийг хийнэ.
 - ☞ Зөрүүтэй урамшууллаас үүдэлтэй кредитийн хэмжээг зориудаар ихсэхээс сэргийлэх (Жишээ нь: кредитийн хэмжээгээ өсгөхийн тулд урамшууллаар хөшүүргэдэж гарах үр дүнгийн хэмжээг ихэсгэх).

- ☞ Санал болгож буй аргазүйн маягт болон санал болгож буй аргазүйн хүснэгтүүдийг Англи хэл дээр бөглөнө.
- ☞ Санал болгож буй аргазүйн маягтын фонт, бүтэц, формат, гарчигийг өөрчлөхгүйгээр ашиглах ёстой. Хэрэв санал болгож буй аргазүйн маягт нь ашиглахад тохиромжгүй бол шалтгаанаа дурдан хоосон орхино.
- ☞ Санал болгож буй аргазүйн маягт болон санал болгож буй аргазүйн хүснэгтүүдэд байгаа тоон утгууд нь олон улсын стандартад нийцсэн форматын дагуу байна (жиш: 1,000 гэдэг нь нэг мянга, 1.0 гэдэг нь нэгийн тоог илэрхийлнэ). Ил тод, ойлгомжтой байдлыг хангахын тулд тухайн тоон утгуудын нэгжүүдэд нь нэгж/норм(мянга/сая) эквивалент нэгжийг ашигласан байх ёстой.

ХКОМ-ын салбарын хамрах хүрээ нь [GL PM ver.2

Annex I] ХКОМ-ын төслүүдэд хамаарах ялгарч буй хүлэмжийн хийн ялгаралын эх үүсвэрүүдийн ангилал юм. ХКОМ-ын төсөл нь хэд хэдэн салбарыг хамарч болно:

- | | | |
|--|--|--|
| 1. Эрчим хүчний үйлдвэрлэл (сэргээгдэх/үл сэргээгдэх эх үүсвэр); | 4. Боловсруулах аж үйлдвэр; | 11. Галокарбон, гексафторт нүүрстөрөгчийг хэрэглэх, үйлдвэрлэх үеийн дэгдэмхий ялгаралт; |
| 2. Эрчим хүчний түгээлт; | 5. Химийн үйлдвэрлэл; | 12. Уусгагчийн хэрэглээ; |
| 3. Эрчим хүчний хэрэглээ; | 6. Барилга; | 13. Хог хаягдлын менежмент; |
| | 7. Тээвэр; | 14. Ойжуулалт нөхөн сэргээлт; |
| | 8. Уул уурхай/эрдсийн үйлдвэрлэл; | 15. Хөдөө аж ахуй. |
| | 9. Металын үйлдвэрлэл; | |
| | 10. Түлш (хатуу, шингэн, хий) олборлох үеийн дэгдэмхий ялгаралт; | |

4-5. Санал болгож буй аргагүйг мэдүүлэх үйл явц

Аргагүйн саналыг боловсруулагч

Мэдүүлэг

(1) Санал болгож буй аргагүйг бэлтгэн цахим шийдвэрээр батлуулахын тулд ХХ-нд мэдүүлнэ (нарийн бичгийн газраар дамжуулан).

- ☞ Санал болгож буй аргагүй нь
 - 1) Бүрэн гүйцэд бөглөсөн “ХКОМ-ын санал болгож буй аргагүйн маягт”
 - 2) аргагүйн зааварчилгааны дагуу боловсруулсан Тоон мэдээг оруулах хүснэгт болон Тооцооллын үйл явцын хүснэгт г.м хуудсуудыг багтаасан “ХКОМ-ын санал болгож буй аргагүйн хүснэгтийн хуудас”
- ☞ Санал болгосон арга зүйн өмнөх хувилбарыг шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор ашиглаж болно.
- ☞ Мэдүүлэгт аргагүйг тайлбарласан нэмэлт мэдээллийг хавсаргаж болно.

(5') Нарийн бичгийн газраас бүрэн бус гэж үзсэн аргагүйг ахин мэдүүлж болно. Мэдүүлэгт нарийн бичгийн газраас бүрэн бус гэж тодорхойлсон асуудлын шалтгааныг дурдана.

Нарийн бичгийн газар

(2) Цахим хэлбэрээр мэдүүлгийг хүлээн авсныг аргагүйн санал боловсруулагчид мэдэгдэнэ.

Бичиг баримтын бүрэн гүйцэд эсэхийг шалгах(календарийн 7 өдөрт багтаана)

(3) Санал болгож буй аргагүй нь бүрэн гүйцэд эсэхийг шалгаж аргагүй боловсруулагчид мэдүүлгийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор үр дүнг мэдэгдэнэ.

Бүрэн бус

(4') Хэрэв мэдүүлэг нь бүрэн бус байвал нарийн бичгийн газар аргагүй боловсруулагчид бүрэн бус байгаа шалтгааныг мэдэгдэнэ.

Олон нийтийн санал (календарийн 15 өдөр)

(4) Санал болгож буй аргагүйг мэдүүлсний дараа бүрэн гүйцэд байдлыг хангаж байвал тэр даруйд нь ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил болгож саналыг авч эхэлнэ. Олон нийтийн санал авах хугацаа нь календарийн 15 өдөр байна.

(5) Нарийн бичгийн газар нь олон нийтээс ирсэн бүх саналыг ХКОМ-ын цахим хуудас дээр олон нийтэд нээлттэйгээр мэдээлнэ.

Хамтарсан Хороо

(1') Хамтарсан Хорооны санаачлагын дагуу санал болгож буй аргагүйг боловсруулах

Дууссан

4. ХКОМ-ын төслийн аргазүй

4-5. Санал болгож буй аргазүйг мэдүүлэх үйл явц

Аргазүйн саналыг боловсруулагч

Нарийн бичгийн газар

Хамтарсан Хороо

Үнэлгээ хийх (календарийн 60-90 өдөрт багтаах)

- (6) Аргазүйн зааварчилгааны дагуу авсан олон нийтийн санал болон Аргазүйн саналыг боловсруулагчийн мэдүүлсэн материалуудыг үндэслэн үнэлгээ хийх
- Санал болгож буй аргазүйг боловсруулагч талтай тухайн аргазүйн асуудлаар холбогдон мэдээлэл авч болно.
 - Аргазүйн саналыг боловсруулагчаас хараат бус мэргэжлийн шинжээч болон мэргэжлийн хүмүүсээр үнэлгээг хийлгэх боломжтой.

Шийдвэр гаргах (60 хуанлийн өдрийн дотор)

- (7) Хэрэв явагдаж буй тодруулга гэх мэт асуудлаас болж энэ үйл явц боломжгүй болвол нарийн бичгийн газар аргазүйн саналыг боловсруулагчид хэлэлцүүлгийн сүүлийн үеийн байдлыг олон нийтийн саналыг авч дууссанаас 60 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд ХХ нь олон нийтийн саналыг авч дууссанаас хойш 90 календарийн хоногт багтаан дүгнэлтийг гаргана.

Дахин хүсэлт гаргах

(9') ХХ-оор хэлэлцэгдэн батлагдаагүй аргазүйг ахин мэдүүлж болно. ХХ-р батлагдаагүй шалтгааныг аргазүйг дахин мэдүүлэхдээ дурдана.

Батлагдахгүй нөхцөл

(8) Нарийн бичгийн газраас аргазүйг шалгаж үзсэн дүгнэлт дээр үндэслэн гарсан үр дүнг аргазүйн саналыг боловсруулагчид шалтгааны хамт мэдэгдэнэ.

Батлах

Аргазүйг олон нийтэд нээлтэй болгох (календарийн 5 өдрийн дотор)

(9) ХХ-ноос аргазүйг батлах шийвэр гарснаас хойш хуанлийн 5 өдрийн дотор Батлагдсан аргазүйн баримт бичиг, мониторингийн хүснэгт гэх мэт мэдээллийн хамт ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгоно.

Санал болгосон аргазүйг батлах


Залруулгатайгаар тухайн санал болгосон аргазүйг батлах;

Санал болгосон аргазүйг батлахгүй

4-6. Батлагдсан аргазүйд ахин өөрчлөлт оруулах үйл явц

4. ХКОМ-ын төслийн аргазүй

[PCP ver.6, para 92-105]



5-1. ТББ-ийг боловсруулах

[GL PDD ver. 3.1, para 3., 9-13, 16-22]

- ◆ Төслийн баримт бичгийг ХКОМ-ын дүрэм, журмын дагуу бүх холбогдох мэдээллийг багтааж ХКОМ-ын Төсөлд Оролцогч тал боловсруулна.
- ◆ Санал болгох ХКОМ-ын төсөл, ТББ болон мониторингийн тайлан мэдээллийг боловсруулахдаа ТО тал нь батлагдсан аргазүйн баримт бичгүүд болон мониторингийн хүснэгтийг багтаасан ТББ-ийг Мониторинг хийх журмын дагуу боловсруулан сонгосон аргазүйн хамт хүргүүлнэ.

Төслийн Баримт Бичиг

ТББ нь бүрэн гүйцэд бөглөсөн ТББ-ийн маягт, Мониторингийн төлөвлөгөөний хүснэгтийг ашиглан гаргасан мониторинг хийх төлөвлөгөө болон Мониторингийн бүтцийн хүснэгтээс бүрдэнэ.

ТББ-ийн маягт

ХКОМ-ын ТББ –ийн маягт хув. 3.1

Мониторингийн төлөвлөгөө

Мониторингийн төлөвлөгөөний хүснэгт

Мониторинг хийх бүтцийн хүснэгт

- ☞ ТО нь тухайн төслийн ерөнхий утга, хэрэгжилтийн талаарх танилцуулгыг тусгах
- ☞ ТО нь бүртгэгдсэн ХКОМ-ын төсөлд болон түүний ХүХ-н ялгаралын бууралтад хяналт тавих. ТО нь төслийн мэдээлэл, тоон мэдээнд чанарын менежментийн үйл явцыг тодорхойлон хэрэгжүүлнэ. ТО нь ялгаралын бууралтын тооцооллын үед гарах тодорхойгүй байдлыг аль болох бодитойгоор бууруулах ёстой.
- ☞ Холбогдох батлагдсан аргазүйд өөрчлөлт орсон тохиолдолд Мониторингийн хүснэгтэд өөрчлөлт орно.
- ☞ ТББ-ийн маягт болон мониторингийн хүснэгтийг Англи хэл дээр бөглөсөн байна.
- ☞ ТББ болон Мониторингийн хүснэгтийн формат, фонт, гарчиг зэрэгт өөрчлөлт оруулахгүйгээр бүрэн гүйцэд бөглөх бөгөөд мөр нэмэх тохиолдолд ТББ-ийн маягтийн хавсралтад байгаа хүснэгтийг ашиглана.
- ☞ Хэрэв ТББ-т багтаж буй мэдээллийн аль нэг хэсэгт ТО-ийн талаас нууцлах шаардлагатай, өмчлөх эрхтэй холбоотой мэдээлэл багтсан бол ТО нар нь баримт бичгийг 2 хувилбараар мэдүүлнэ. (1) эхний хувилбар дээр өмч, санхүү, нууцлалтай холбоотой мэдээллүүдийг бүгдийг тодорхой бус оруулах (2) дараагийн хувилбар дээр бүх мэдээллийг оруулан хатуу нууцлалтай болгох
- ☞ Шалгуур үзүүлэлт болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэрэгтэй холбоотой мэдээллүүд нь нууцлалд багтахгүй.
- ☞ ТББ-т буй ялгаралын бууралтын тооцооллыг хийхэд шаардагдах тоон мэдээ нь ил тод, тодорхой байхын тулд олон улсын түвшинд мөрдөгдөх стандарт нэгжийг хэрэглэнэ.
- ☞ 2013 оны 1 сар болон түүнээс хойш хугацаанд ХКОМ-ын төсөл болж хэрэгжих төслүүдийн үйл ажиллагаа эхлэнэ. Урьдчилсан байдлаар төслийн ашиглалтын хугацааг олон нийтэд нээлттэй статистикийн тоон мэдээ болон ижил төстэй төслүүдийн суурь тоон мэдээ, хуулийн хүрээнд үргэлжлэх хугацаа гэх мэт мэдээллүүд дээр үндэслэн тодорхойлно.

Тайлбар: Мониторингийн тайлан болон ТББ-ийг боловсруулах ХКОМ-ын журам (ТББ болон Мониторингийн журам) [GL PDD ver.3.1]

☞ Эдгээр нь ХКОМ-ын ТББ болон Мониторингийн тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай.

5-2. Мониторингийн төлөвлөгөө

[GL PDD ver.3.1, para 5, 23-28]

◆ Мониторингийн төлөвлөгөө нь ТО-ын ашиглах аргазүйг тогтоох, харин ГТЭ-ийн хувьд ХКОМ-ын төслийн ХүХ-н ялгаралын бууралтад хүрсэн хэмжээг нотлох юм. ТО нь магадлагааны өмнө ашигласан аргазүйн Мониторингийн Хүснэгтийн Мониторингийн төлөвлөгөөний хуудас, Мониторингийн бүтцийн хуудсуудыг ашиглан мониторингийн төлөвлөгөөгөө боловсруулна.

ТО-д тавигдах шаардлага

ТО-д нь:

- ☞ Мониторингийн төлөвлөгөөний хуудаст байгаа параметр бүрийн тооцоологдсон, урьдчилан засвар орсон тоон мэдээг мониторингийн төлөвлөгөөнд оруулах
- ☞ Ашигласан аргазүйд зааснаар Мониторингийн төлөвлөгөөний хуудаст заасан параметр бүрийн баруун талд бичигдсэн зүйлсийг тайлбарлаж ашигласан аргазүйн бүтцийн дагуух санал болгож буй төсөлд шаардлагатай дэлгэрэнгүй мэдээллийг нэмж өгч болно.
- ☞ Мониторинг, нотолгоонд шаардлагатай тоон мэдээ зэргийг цахим хэлбэрээр хадгалж архив болгон кредит олгосноос хойш 2 жилийн турш хадгална.
- ☞ Мониторингийг хэрэгжүүлэхэд шаардлагатай менежментийн болон удирдан явуулах бүтцийг тайлбарлана. ТО нь мэргэжилтэн, салбар дундын зохицуулалт, тоон мэдээ цуглуулах үйл явц, архивлах, тайлагнах үйл явцыг гүйцэтгэхэд шаардлагатай үүргийг тодорхой болгосон байна.
- ☞ Мониторингийг хариуцан хийх, мониторингийн тайланг бэлтгэх, тоон өгөгдөл мэдээг зохицуулах, архивлах ажлуудыг хариуцах хүнийг томилно. Хариуцах хүн нь:
 - (a) Тайлангийн бүтэц, үйл явц, мониторингийн тайлангийн чанарт анхаарч ажиллах;
 - (b) Мониторингийн цэгүүдийг зохицуулж шаардлагатай бол тухайн цэгүүд дээр тоон мэдээ өгөгдлийг цуглуулж тогтвортой байдлыг ханган хэмжилт хийх хэрэгслүүдийг хянах (калибраци/энгийн хяналт).

ТО нарын тайлбар хийх асуудлууд :

- (a) Ойролцоогоор тооцоолсон тоо: ялгаралын бууралтыг урьдчилан тооцоолохын тулд параметрт ашигласан ойролцоогоор тооцоолсон тооцоолол;
- (b) Мониторингийн сонголт: Доорхоос сонгоно;
 - (i) Сонголт А: ТО-оос гадна бусад этгээдийн хийсэн олон нийтэд зориулагдсан өгөгдөл (ашигласан өгөгдөл: олон нийтийн мэдэх статистикийн мэдээ болон тодорхойлолтууд);
 - (ii) Сонголт В: гүйлгээний хэмжээнд суурилсан хэмжих хэрэгслийг шууд ашиглан хэмжиж гаргасан дүн (ашиглагдсан өгөгдөл: нэхэмжлэх мэтийн түгээмэл нотлох баримтууд);
 - (iii) Сонголт С: төхөөрөмж ашиглан хэмжсэн бодит хэмжилт (ашигласан өгөгдөл: хэмжсэн тоон мэдээ).
- (c) Эх үүсвэрийн өгөгдөл: ашиглагдах болон ашиглагдаж байгаа өгөгдлийн эх үүсвэрийг дурдана. Өгөгдлийн эх үүсвэрийн төрлийг тодорхой бичнэ. (Жишээ нь. Өдөр тутмын хэмжилт, хэмжилтийн дэвтэр, асуулгууд гэх мэт) мөн орон зайн түвшний өгөгдөл (Жишээ нь. Орон нутгийн, бүсийн, үндэсний, олон улсын)
- (d) Хэмжилт хийх арга, үйл явц: Чанарын баталгаа/чанарын хяналтын үйл явцыг ашиглаж буй үед параметруудийг хэрхэн хэмжих/тооцоолох талаар тайлбар хийнэ. Хэрэв параметруудийг хэмжвэл хэмжихэд ашиглагдаж буй төхөөрөмжүүдийн талаар баталгааны түвшин, калибраци хийх мэдээлэл зэргийг оруулсан тайлбар хийнэ. (давтамж, магадлах болон калибраци хийсэн огноо)
- (e) Мониторинг хийх давтамж: мониторинг хийх давтамжийг тайлбарлана. (Жишээ нь: тасралтгүй, жил бүр)

5-3. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө боловсруулах

- ◆ ТХТӨ нь ХКОМ-ынтөслийн төлөвлөлтийн хүлээгдэж буй үр дүнгийн өмнөх /ex-ante analysis/ задлан шинжилгээнд үндэслэн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг тодорхойлно.
- ◆ ТХТа нь ТХТө-ний хяналт шинжилгээний тухайн хугацааны гүйцэтгэлийн ололт амжилтыг ТХТа-ийн хяналтын жагсаалтын дагуу хийсэн үнэлгээнд тулгуурлан тодорхойлно. /ex-post evaluation/

Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөнд:

- Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр болон гарч болзошгүй сөрөг үр дагаварыг 8 хэсэгт хуваан тодорхойлон оруулна.
 - Бодлогын зохицуулалт:** төсөл нь өөрийн салбар, технологи болон газар зүйн бүсэд хамаарах Монгол улсын одоогийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдсан байх.
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ:** төсөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний албан ёсны хууль эрх зүйн явцыг дагаж мөрдөх шаардлагатай.
 - Бохирдолын хяналт:** төсөл нь агаар, ус, хог хаягдал, дуу чимээ, чичиргээ, үнэр зэрэг бохирдуулагчыг ялгаруулдаг эсэх.
 - Эрүүл мэнд ба аюулгүй байдал:** төсөл нь орон нутгийн иргэд болон төсөлд хамаарагдах хуулийн этгээдүүдэд барилгын болон үйл ажиллагааныхаа явцад аюултай байдал үүсгэж байгаа эсэх.
 - Байгаль орчин ба биологийн олон янз байдал:** төсөл нь дархан цаазат газар байрладаг эсэх гэх мэт.
 - Эдийн засаг:** орон нутгийн ажиллах хүчний чадавхид сөрөг нөлөө үзүүлэх эсэх гэх мэт.
 - Нийгэм ба олон нийтийн оролцоо:** төсөл нь тухайн бүс нутагт нүүлгэн шилжүүлэлт, бусад төрлийн зөрчилдөөн үүсгэх гэх мэт.
 - Технологи:** төсөл нь төслийн үйл ажиллагааны явцад шууд хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эсэх
- Тогтвортой хөгжлийн 17 зорилтот оруулж болох боломжит хувь нэмэр

Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайланд:

- Төлөвлөгөөнд тусгасны дагуу дараах 8 зүйлийн жагсаалтын дагуу төслийн зүгээс гарсан сөрөг үр дагавар (илэрсэн/илрээгүй)-ыг жагсаалтын дагуу тодорхойлон оруулна.
- Мониторингийн явцад тогтвортой хөгжлийн 17 зорилтот оруулсан хувь нэмэр

ТО талаас дараах байдлаар тодорхойлолно:

- Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр болон гарч болзошгүй сөрөг үр дагаварын төлөвлөгөө
 - ☞ Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр эсвэл гарч болзошгүй сөрөг үр дагаварыг 22 асуултын дагуу “Тийм” “Үгүй” гэсэн байдлаар хариулна.
 - ☞ Хэрвээ “Тийм” гэсэн хариулт өгвөл ТО тал төлөвлөгөөндөө тогтвортой хөгжилд сөрөг үр дагавар учруулж болзошгүй үр дагаварыг хэрхэн залруулах арга хэмжээний талаар тодорхой тусгаж өгнө.
- Тогтвортой хөгжлийн 17 зорилтот оруулах боломжит хувь нэмэр
 - ☞ ТХЗ-д оруулах боломжит хувь нэмрийг нэг бүрчлэн тодорхойлох
 - ☞ Хэрвээ боломжит хувь нэмэр тодорхойлогдвол тайлбар бичих

ТО талаас дараах байдлаар тодорхойлолно:

- Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр болон гарч болзошгүй сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх
 - ☞ Тухайн төслийн явцад сөрөг үр дагавар “Илэрсэн” “Илрээгүй” гэсэн байдлаар бэлтгэсэн 22 асуултанд хариулах
 - ☞ Хэрвээ төслийн зүгээс тогтвортой хөгжлийн байдал ямар нэг сөрөг үр дагавар “Илэрсэн” бол тухайн сөрөг үр дагаварыг залруулсан арга хэмжээг тодорхой тусгана.
- Тогтвортой хөгжлийн 17 зорилтот оруулах боломжит хувь нэмэр
 - ☞ ТХЗ-д оруулсан хувь нэмэр, ололт амжилтыг нэг бүрчлэн тодорхойлох
 - ☞ Хэрвээ боломжит хувь нэмэр тодорхойлогдвол тайлбар бичих. Хэрэв боломжтой бол тоон үзүүлэлтийг хэрэглэх.

☞ **ТХЗ-д оруулах хувь нэмрийн үзүүлэлтүүд:** ТХЗ-д оруулсан хувь нэмрийг тодорхойлсон тохиолдолд ТО тал нь ТХЗ-ийн шалгуур үзүүлэлтүүдийг “ Дэлхийн ТХЗ-ийн шалгуур үзүүлэлтийн хамрах хүрээ ба Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэл хөтөлбөр”-өөс харна уу. [<https://unstats.un.org/sdgs/indicators/indicators-list/>].³

6-1. Магадлагаанд тавигдах шаардлага

[GL VV ver.1, para 5, 18-76, 79]

- ◆ Магадлагаа Нотолгоо хийх журмын эсрэг ГТЭ нь хараат бус байдлаар ХКОМ-ын төсөлд үнэлгээ хийх үйл явцыг магадлагаа гэнэ.
- ◆ ГТЭ нь:
 - (a) ХХ-ноос гаргасан шийдвэр болон магадлагаа нотолгооны журам болон ашигласан аргазүйд тавигдах шаардлагуудтай санал болгож буй ХКОМ-ын төсөл нь хэрхэн нийлж байгааг тодорхойлно.
 - (b) ТББ болон ХаХ-т тусгасан урьдчилсан төсөөлөл болон шаардлагуудыг үнэлнэ. Энэ үнэлгээнд ашиглагдах нотлох баримт нь зөвхөн ТО-ийн өгсөн баримт нотолгоогоор хязгаарлагдахгүй.
- ◆ Магадлагааны тайлан нь ГТЭ-ийн магадлагааны үйл ажиллагааны явц болон магадлагааны үр дүнгийн талаар илтгэх ерөнхий тойм.

- ◆ Ерөнхий шаардлагууд: ГТЭ нь магадлагааны хүрээнд санал болгож буй ХКОМ-ын төслийн технологитой ойролцоо эсвэл төсөлтэй холбоотой боломжит суурь мэдээллүүд, баримт бичгийн шүүмж тойм, дараагийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх зэрэг зүйлс дээр тулгуурлан МН-ны журмын дагуу тодорхойлсон магадлагааны үр дүн хэрэгжиж байгаа эсэх болон ТО-ын мэдүүлсэн мэдээллүүдийг үнэлнэ. Магадлагааны онцгойлон тодорхойлсон үр дүн байхгүй бол ГТЭ нь ердийн аудитын арга барилыг ашиглана.
- ◆ ТББ-ийн маягт: ГТЭ нь ТББ болон Мониторингийн журамд заасны дагуу ТББ-ийн хамгийн сүүлийн маягтыг бүрэн гүйцэд бөглөн ашигласан эсэхийг тогтооно.
- ◆ Төслийн тодорхойлолт: ГТЭ нь ТББ-д дурдсан ХКОМ-ын төслийн танилцуулга нь тодорхой, бүрэн гүйцэд, ХКОМ-ын төслийн талаар хангалттай мэдээлэл өгч байгаа эсэхийг тогтооно.
- ◆ Батлагдсан аргазүйн хэрэгжүүлэлт: ГТЭ нь сонгосон аргазүйг авч ашиглахад тохирох эсэх, тухайн тохирох хувилбар нь ХКОМ-ын төслийг магадлагаанд мэдүүлэх үед хугацаа нь хүчинтэй байгаа эсэхийг тогтооно.
- ◆ Ялгаралын бууралтын тооцоолол болон ялгаралын эх үүсвэрүүд: ГТЭ нь ХКОМ-ын санал болгож буй төслийн суурь ялгарал болон төслийн ялгаралыг тооцоолохын тулд аргазүйд багтсан бүх ХүХ-н эх үүсвэрүүдийг багтсан эсэхийг тогтооно. ГТЭ нь Мониторингийн төлөвлөгөөний хуудаст багтсан төслийн тусгай параметруудийг урьдчилан засах эсэхийг тодорхойлно.

- ◆ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ: ГТЭ нь Монгол улсад хийх ёстой байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг ТО тал заасан шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг тогтооно.
- ◆ Орон нутгийн оролцогч талуудын зөвлөлдөх ажиллагаа: ГТЭ нь ТО талын орон нутгийн оролцогч талуудтай зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлж санал болгож буй төсөлдөө тэдгээр саналуудыг тусгасан эсэхийг тогтооно.
- ◆ Мониторинг: ГТЭ нь мониторингийн төлөвлөгөөний тодорхойлолт нь мониторингийн журам болон ТББ эсвэл батлагдсан аргазүйд суурилсан эсэхийг тогтооно. ГТЭ нь хэмжилт хийсэн мониторингийн цэгүүд нь хүлээн зөвшөөрөхүйц эсэх, хэрэв шаардлагатай бол ирээдүйд суурилуулах тоног төхөөрөмжийн зохистой эсэхийг тогтооно.
- ◆ Олон нийтийн санал: ТО-ын мэдүүлснээр төслийн үйл явцад мэдүүлсэн санал болгож буй ХКОМ-ын төслийн ТББ-т бүх саналууд туссан эсэхийг ГТЭ тогтооно.
- ◆ ХаХ: ГТЭ нь бүх ТО талууд, ХаХ-т тусгагдсан төслийн төлөөлөгчийн хувь нийлүүлсэн байдлыг хувь хүмүүсийн бичиг баримтууд болох гарын үсгийн загвар, ажил эрхэлсэн байдал, баталгаат гарын үсэг гэх мэт зүйлсийн хамт магадлана.
- ◆ Давхар бүртгэлээс зайлсхийх: ГТЭ нь тухайн төсөл нь олон улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах аль нэг механизмд бүртгэгдээгүй эсэхийг хянан тогтооно.
- ◆ Хэрэгжиж эхлэх: ГТЭ нь ХКОМ-ын төслийн хэрэгжиж эхлэх хугацаа 2013 оны 1 дүгээр сарын 8-наас хойш байгаа эсэхийг тогтооно.

6-1. Магадлагаанд тавигдах шаардлага

[GL VV ver.1, para4]

6. Бүртгэл

☞ Норматив эшлэлүүд:

Дараах эш авсан баримт бичгүүд нь Магадлагаа Нотолгооны (МН) журмыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай:

- (a) “ISO 14064-3:2006 Хүлэмжийн хий-3 дугаар хэсэг: Хүлэмжийн хийн баталгааны магадлагаа нотолгоог хийх зааварчилгааны тодорхойлолтууд”
- (b) Төслийн үйл явц
- (c) ТББ ба мониторингийн хийх зааварчилгаа

Тайлбар: ХКОМ-ын Магадлагаа Нотолгооны журмын болон ISO 14064-3 стандартын хамрах асуудлууд

	Агуулга	ХКОМ МН Зааварчилгаа	ISO14064-3
Ерөнхий зүйл	Агуулга	1	Танилцуулга
	Хамрах хүрээ, боломж	2, 3	1
	Норматив эшлэл	4	-
	Нэр томьёоны тодорхойлолт	5-11	2
	Үүрэг, хариуцлага	ROI 25-26, 32-33	
Ерөнхий магадлагаа, нотолгооны үе шат	Зарчмууд		3
	ГТЭ	13-15	4.1
	Ерөнхий магадлагаа, нотолгооны шаардлагууд	16	
	Магадлагааны арга	18	4.2, 4.4
	Магадлагаа гэж юу вэ	12, 19-21	4.2, 4.4
Магадлагаа, нотолгооны төлөвлөгөөг боловсруулах	Нотолгооны арга	82-86	4.2, 4.4
	Нотолгоо гэж юу вэ	12, 90-92	4.2, 4.4
	Магадлагаа, нотолгооны түвшин	99 (verification)	4.3.1
	Бодит байдал	100-101(verification)	4.3.5
	Хамрах хүрээ	-	4.3.4
	Төслийн үйл ажиллагаа, төслийн хэрэгжилтийн орчныг бүрдүүлэх	-	4.4.1
	Эрсдэл үнэлгээ	-	4.4.1
Магадлагааны шаардлага	Дээж авах	17	4.4.3
	Төлөвлөгөө гаргах	-	4.4.2
	Магадлагааны асуудлууд		
	Төслийн баримт бичгийн маягт	28, 29	-
	Төслийн тайлбар	30-32	-
	Батлагдсан арга зүйн анкет	33-37	A.2.4.6.2 A.2.6.1
	Ялгаралын эх үүсвэр, ялгаралын бууралтын тооцоо	38-46	A.2.4.6.2 A.2.6.1
	Байгаль орчны үнэлгээ	47-49	-
	Оролцогч талуудын уулзалт	50-52	-
	Мониторинг	53-56	A.2.4.6.2 A.2.6.1
	Олон нийтийн санал	57-60	-
	Харилцааны арга хэлбэр	61-69	-
	Давхар бүртгэлээс сэргийлэх	70-73	-
Үйл ажиллагааг эхлүүлэх	74-76	-	
Асуудлыг тодорхойлох	22-27	-	
Магадлагааны тайлан гаргах	29-73, 77-80, 81	4.9	

	Агуулга	ХКОМ МН Зааварчилгаа	ISO14064-3
Ерөнхий зүйл	Агуулга	1	Танилцуулга
	Хамрах хүрээ, боломжууд	2, 3	1
Тавигдах шаардлага	Норматив эшлэл	4	-
	Асуудлыг тодорхойлох	22-27	-
Нотолгоонд тавигдах шаардлага	Магадлагааны тайлан	29-73, 77-80, 81	4.9
	Нотолгооны асуудлууд		
	Төслийг хэрэгжүүлэхэд мөрдөж буй арга зүйн шалгууртай нийцэж байгаа эсэх	102-104	4.7
	Төслийн хэрэгжилтийн үнэлгээ нь бүртгэгдсэн ТББ болон баталсан ТББ-д орсон өөрчлөлтүүдийг тусгасан эсэх	105-107	-
	Хэмжлийн утгуудын давтамж, залруулгыг холбогдох шаардлагуудтай нийцүүлэх	108-113	-
	ХүХ-н ялгаралын бууралтын тооцооллын үнэлгээ	114-116	4.5-4.8
	Давхар бүртгэлээс сэргийлсэн үнэлгээ	117-120	-
	Бүртгэлийн дараах өөрчлөлтүүд	121-125	-
	Асуудлыг тодорхойлох	93-98	-
	Нотолгооны тайлан	126-128	4.9
Магадлагаа, нотолгооны үр дүнгийн үнэлгээ	Дотоод хяналтад тулгуурласан шаардлага	-	4.5
	Нотолгооны чанар	87-89 нотолгоон дээр	4.6
	Магадлагаа, нотолгооны шалгуурыг үнэлсэн үнэлгээ	-	4.7
	ХүХ-н нотолгооны үнэлгээ	-	4.8
	Магадлагаа, нотолгоонд тавих санал	-	4.9
Чанарын баталгаажуулалт/ чанарын хяналт	Магадлагаа, нотолгооны чанарын хянан шалгалт	-	A.2.2.5 ISO65 8.5
	Бичлэг, хадгалалт	-	4.1
	Магадлагаа, нотолгоо хийсний дараа гарсан алдаанууд	-	4.11

6-2. ТББ-ийг нийтлэх

[PCP ver.6, para 30-45]

Төсөлд оролцогч тал

Мэдүүлэг

- (1) ТББ болон Мониторингийн дүрэм журмын дагуу бүрэн гүйцэд бөглөсөн ТББ-ийн маягт болон мониторингийн төлөвлөгөө, ТХТө зэргийг багтаасан ТББ-ийн төслийг бэлтгэн ХаХ болон дагалдах нэмэлт бичиг баримтыг бүрдүүлж ТО-ын гэрээ байгуулснаар ГТЭ-д баримт бичгийг хүлээлгэн өгч ХХ-нд мэдүүлнэ.
- ТББ, ХаХ-ийн баримт бичгийн өмнөх хувилбарын хуудсыг шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор хэрэглэж болно

Гуравдагч талын этгээд

- (2)' Магадлагаа Нотолгоо хийх журмын дагуу ТББ-ийн төсөлд тусгасан санал болгож буй ХКОМ-ын төсөл болон ХаХ-ийг магадлаж "ХКОМ-ын Магадлагааны Тайлангийн Маягт"-ийг ашиглан магадлагааны тайланг боловсруулж ТО-д тайланг гарган өгнө.
- (5)' Хэрэв ямар нэг эргэлзээтэй зүйл гарвал энэ мэдээллийн баталгаатай эсэх, уялдаа холбоог ахин шалгана.

Тайлбар: Магадлагаа болон Нотолгоо

Магадлагаа нотолгоо нь дангаар эсвэл зэрэг хийгдэж болно. ТО талууд магадлагаа нотолгоонд зэрэг орох бол бүх баримт бичгийг мэдүүлэх үед ТББ-ийн төслийн бүх хэсэг, Мониторингийн тайлан бүрэн гүйцэд байх ёстой.

Нарийн бичгийн газар

Төслийн хувийн дугаарыг олгох

- (3) Мэдээллийг хүлээн авч төсөлд өгч буй тусгай дугаарын тухай мэдэгдэнэ.
- ТББ болон ХаХ-ийн төслийг хүлээн авснаа төсөлд оролцогч талд мэдэгдэнэ.

Олон нийтийн санал (календарийн 30 хоног)

- (4) ТББ-ийн төслийг ХКОМ-ын вэбхуудсаар дамжуулан олон нийтэд ил болгоно.
- Нарийн бичгийн газраас ТО болон ГТЭ-д ХКОМ-ын төслийн олон нийтийн саналыг байршуулсан цахим хуудас болон үргэлжлэх хугацааны талаар мэдэгдэнэ.
- Бүх оролцогч талууд ХКОМ-ын төсөлд оролцогч талууд болон ГТЭ-д ирүүлэх саналаа Англи хэл дээр электрон хэлбэрээр ирүүлж болно.

Төслийн мэдээллийг олон нийтэд ил болгоно.

- (5) Дараах мэдээллүүдийг ХКОМ-ын цахим хуудас дээр нийтэлнэ;
- (a) Санал болгож буй ХКОМ-ын төслийн нэр;
- (b) ХКОМ-ын төсөл хэрэгжих газарзүйн байршлыг солбилцлын хамт;
- (c) ХКОМ-ын ТББ-т дурдсан бүх ТО-талуудын нэрс;
- (d) Санал болгож буй ХКОМ-ын төслийн Магадлагаа (нотолгоо)-г гүйцэтгэж буй ГТЭ;
- (e) ТББ-т дурдсан жилд бууруулах/шингээх хүлэмжийн хийн ялгаралын бууралтын хэмжээ;
- (f) Тухайн ХКОМ-ын төсөлд ашиглаж буй батлагдсан аргазүй;
- (g) Төсөл эхлэх огноо болон үргэлжлэх хугацаа

- (6) Олон нийтээс ирсэн бүхий л саналыг ТББ-ийн төслийг нийтэлсэн ХКОМ-ын цахим хуудас дээр нээлттэйгээр байршуулах бөгөөд ГТЭ-ийн зүгээс тохиромжгүй, худал гэж үзсэн саналыг устгана.

6-3. Бүртгүүлэх хүсэлт гаргах үйл явц

6-3. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг мэдүүлэх ба хянах

[PCP ver.6, para 39-46]

Төсөлд оролцогч тал

Нарийн бичгийн газар

Мэдүүлэх

(1) Дүрэм журмын дагуу ТХТө-ний баримт бичгийг бэлтгэн, төслийн баримт бичгийг мэдүүлэхдээ бусад хавсаргах бичиг баримтын (шаардлагатай тохиолдолд) хамт нарийн бичгийн газарт илгээнэ.
 ☞ ТХТө-ний баримт бичгийн өмнөх хувилбарын хуудсыг шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор хэрэглэж болно

(2) Бичиг баримтыг хүлээн авсныг мэдэгдэх
 ☞ ТББ болон ХаХ-ийн төслийг хүлээн авснаа төсөлд оролцогч талд мэдэгдэнэ.

ТХТө-ний баримт бичгийг шалгах хугацаа (календарийн 14 хоног)

(3) Дүгнэлт хийх
 ☞ ТХТө-тэй холбоотой асуудлаар ТО талтай холбогдон тодруулга хийж болно.

Болзошгүй сөрөг үр дагавар илэрсэн ч авах арга хэмжээний төлөвлөгөөг тусгаагүй.

Сөрөг үр дагавар илрээгүй эсвэл авах арга хэмжээний төлөвлөгөөг тодорхой тусгасан.

(4) Болзошгүй сөрөг үр дагавар илэрсэн ч авах арга хэмжээний төлөвлөгөөг тусгаагүй талаар ТО талд мэдэгдэх

(5)' ТХТө-ний баримт бичгийг дахин нягтлан засаж илгээж болно.

Эерэг үнэлгээ

Төсөлд Оролцогч

Нарийн бичгийн газар

Хамтарсан Хороо

ГТЭ-ээс магадлагааны тайлан болон ТХТө эерэг хариу авсан бол ТО нь санал болгож буй ХКОМ-ын төслийг бүртгүүлэх хүсэлт гаргаж өгч болно.

Мэдүүлэг

(1) ХКОМ-ын санал болгож байгаа төслийг бүртгүүлэх хүсэлт гаргах.
 ☞ ТО тал нь "ХКОМ-ын төслийг бүртгүүлэх хүсэлт гаргах маягт"-ыг гүйцэд бөглөж, магадлагаа хийлгэсэн ТББ болон ХаХ, магадлагааны тайлан болон бусад дагалдах бичиг баримтыг хавсарган ХХ-руу электрон хэлбэрээр мэдүүлнэ.
 ☞ Баримт бичгийн өмнөх хувилбарын хуудсыг шинэ хувилбар гарснаас хойш 6 сарын дотор хэрэглэж болно

(4)' Хүсэлтийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн мэдүүлнэ.

(5)' Дараах тохиолдолд ТО нар нь нэмж өөрчилсөн (1) төслийн баримт бичгийг бүрдүүлэн ахин бүртгүүлэхээр хүсэлт гаргаж болно.
 ☞ Аргачлалыг өмнөх хувилбарын хүчинтэй байх хугацаанд дахин бүртгүүлэх хүсэлтийг 45-аас дээш хоногт бүртгэх тусгай журам байдаг

(7) Хэрэв хүсэлтийг түдгэлзүүлэх шалтгаан нь ТББ-д ГТЭ-ийн хийсэн дүн шинжилгээ эерэг гарч түүнийг зохистой гэж үзсэн үр дүнд үндэслэн магадлагааны тайлангийн үр дүнгээс хамааралтай бол ахин хүсэлт гаргах боломжтой.

(2) ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан бүртгүүлэхээр гаргасан бүх хүсэлтийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй байлгана.

Бүрэн гүйцэд эсэхийг шалгах (7хоногт багтаах)
 (3) Бүртгүүлэх хүсэлтийн бүрэн гүйцэд байдлыг шалгаж дуусгана.

Үг үсгийн алдаа гарсан

Илгээсэн бүрэн байдлын нийцээгүй

хүсэлт нь гүйцэд шалгуурт
 Эерэг дүгнэлт

(4) ТО тал болон ГТЭ-д мэдэгдэх
 ☞ Хэрэв бүртгүүлэх хүсэлт нь бүрэн гүйцэд байх шаардлагыг хангахгүй тохиолдолд ТО болон ГТЭ-д үүний шалтгааныг мэдэгдэж ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан нийтэлнэ.

Сөрөг дүгнэлт

ХХ-ны шийдвэр
 (5) Бүрэн гүйцэд байдлыг шалгасан үр дүн эерэг гарвал ХХ нь ХКОМ-ын төслийг бүртгэх эсэхийг шийднэ.

Татгалзах шийдвэр


Төслийн мэдээллийг олон нийтэд ил болгоно

(6) Санал болгож буй төслийг ХХ-оос ХКОМ-ын төсөл болгон бүртгэх шийдвэрийг гаргасан бол нарийн бичгийн газар нь ТО болон ГТЭ-д энэ тухай мэдэгдэж ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд төслийн бүртгэлийн талаар нийтэлнэ.

(6)' Хэрэв ХХ тухайн төслийн гаргасан бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзвал нарийн бичгийн газар ТО болон ГТЭ-д татгалзсан шалтгааныг мэдэгдэж ХКОМ-ын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нийтэлнэ.

Мэдээлэл илгээгээгүй

Бүртгэх шийдвэр




7-1. Бүртгэгдсэн ХКОМ-ын төсөлд өөрчлөлт оруулах

[PCP ver.6, para 113-143]

Бүртгэгдсэн төслийн ТББ/аргазүйд өөрчлөлт орж буй тохиолдолд өөрчлөлт гэдгийг дараах байдлаар тайлбарлана:

- (a) Одоогийн хэрэглэж буй аргазүйг ашиглахад учирж буй саадаас шалтгаалан ГТЭ-ийн тодорхойлсон өөрчлөлт;
 - ☞ ТО талууд ТББ-ийг шинэчилж мэдүүлнэ.
- (b) Нотолгоонд тулгуурласан ТО-ын эсвэл ГТЭ-ийн тодорхойлсон магадлагааны үед аргазүйг ашиглахад учрах саадаас шалтгаалан тодорхойлсон өөрчлөлт;
 - ☞ ТО-д нь доор дурдсан үйл явцын дагуу Хамтарсан хороогоор батлуулахаар мэдүүлнэ.
- (c) Одоогийн хэрэглэж буй аргазүйг ашиглахад учруулах саадаас шалтгаалан ГТЭ-ийн эсвэл ТО-ын тодорхойлсон өөрчлөлт.
 - ☞ Энэ тохиолдолд энэхүү тоймын 9-р хэсэгт зааснаар төслөөс нэрээ эргүүлэн татна. Харин тоймын 6-2-т заасны дагуу ТО нь нэрээ эргүүлэн татсан төслийн нэрийн өмнөөс бичиг баримтаа ахин мэдүүлнэ.



7-2. Батлагдсан ХаХ-т өөрчлөлт оруулах

[PCP ver.6, para131-143]

◆ ХКОМ-ын төслийн ТО тал нь бүртгэгдсэн ХаХ-ийн агуулгыг өөрчлөх хүсэлтийг нарийн бичгийн газар руу яаралтай мэдэгдэнэ.

Тавигдах шаардлагууд

- ☞ ТО тал ХаХ-ийн сүүлийн хувилбарыг ашиглан ХаХ-т орох өөрчлөлтөө цахим хэлбэрээр нарийн бичгийн газар руу явуулж болно.
- ☞ ХаХ-ийн маягтийг мэдүүлж буй ТО тал нь дараах зүйлсийг анхаарна:
 - (a) Удирдах зөвлөлийн уулзалтын тэмдэглэл эсвэл өмгөөлөгчийн бүрэн эрхийг илтгэсэн бичиг баримт, компани, ассоциацийн бичиг баримт, компаний улсын бүртгэлийн гэрчилгээ гэх мэт цахим байдлаар нотолгоо хийх боломжгүй шаардлагатай дагалдах бичиг баримтыг мэдүүлэх үедээ тухайн мэдүүлж байгаа хугацаанаас хойш 2 жилийн турш хүчинтэй нотариатаар баталгаажуулан хавсаргана. Энэ хугацаа нь хувь хүний бичиг баримтад хамаарахгүй;
 - (b) Нэгээс дээш ХКОМ-ын төсөлд өөрчлөлт орох боломжтой эсвэл нэг ХКОМ-ын төсөлд олон өөрчлөлт оруулах бол нэг маягтийг ашиглаж болно.
- ☞ Төсөлд оролцогч талын хуулийн этгээд нь холбогдох эрх бүхий гарын үсэг зурах албан ёсны этгээд болон орлогч этгээд нь гарын үсэг зурах боломжгүй болсон тохиолдолд тэдний нэрийн өмнөөс гарын үсэг зурж болно.
- ☞ ТО талын нэрийн өмнөөс гарын үсэг зурсан хуулийн этгээд нь тухайн байгууллагын нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрхтэй гэж бичсэн нотолгоог ирүүлнэ.

Нарийн бичгийн газар:

- ☞ Мэдүүлсэн, бүртгэгдсэн ХаХ-т ямар нэг зөрчилтэй, алдаатай зүйл ажигласан даруйд нарийн бичгийн газар шинэ ХаХ-ийн маягтийг мэдүүлэхийг шаардана.
- ☞ Хэрэв мэдүүлэг нь хангалттай нотлох баримт болж чадахгүй нөхцөлд нэмэлт бичиг баримт, тайлбарыг шаардана.
- ☞ ХКОМ-ын цахим хуудас дээр шинэчлэгдсэн ХаХ-ийг хавсралт 1 болон хүчинтэй хугацааны хамт нийтэлнэ.

Төслийн зохицуулагчийг сайн дураар өөрчлөх

- ☞ Бүртгэгдсэн төслийн ТО талын аль нэг төлөөлөл нь төслийн зохицуулагчийн томилгоог ямар нэг шалтгаанаар, ямар ч үед "Харилцааны арга хэлбэрийн маяг"-ын сүүлийн хувилбарыг ашиглан нарийн бичгийн газар руу цахим хэлбэрээр хүсэн өөрчлөлт хийх боломжтой.
- ☞ Хүсэлтийн маягтын өмнөх хувилбарыг шинэ маягт гарсанаас хойш 6 сарын дотор ашиглан илгээж болно.

ТО-д өөрчлөлт оруулах

- ☞ Хэрэв төсөл бүртгэгдсэнээс хойш ТО талуудын дунд өөрчлөлт гарсан бол доор дурдсан өөрчлөлт бүрт ТО тал ХаХ-ийн маягтийн хавсралт 1-ийг мэдүүлнэ:
 - (a) Шинэ ТО нэмэгдэх;
 - (b) Холбогдох байгууллага этгээдийн нэр/статуст өөрчлөлт ороход;
 - (c) ТО нэрээ татахад . Хэрэв ТО нь бусад шалтгаан болон дампуурсны улмаас үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болж ХаХ-ийн маягтад гарын үсэг зурах боломжгүй болсон тохиолдолд зогсоох ажлыг баримтжуулан нотолгоогоор дамжуулан хийнэ;
 - (d) Холбоо барих мэдээлэл болон загвар гарын үсгийг солих тохиолдолд
- ☞ ХКОМ-ын төсөлд ТО нэмэгдэх үед ХаХ-ийг шинэчлэн мэдүүлээгүй тохиолдолд шинэ ТО нь одоо байгаа ХаХ-г хүлээн зөвшөөрнө.

8-1. Нотолгоо хийхэд тавигдах шаардлагууд

[GL VV ver.1, para 6, 82-126]

- ◆ Нотолгоо гэдэг нь тодорхой хугацааг хамарсан бие даасан хянах ажиллагаа бөгөөд нотолгоо хийх явцад бүртгэгдсэн ХКОМ-ын төслийн үр дүнд буурсан хүлэмжийн хийн ялгаралд ГТЭ-ийн хийсэн мониторинг дээр үндэслэгдэн хийгдэнэ.
- ◆ ГТЭ нь ХХ-ны шийдвэр болон холбогдох журам, ашиглагдаж байгаа аргазүйн шаардлагуудтай тухайн төсөл нь нийцэж буй эсэхийг тодорхойлно.
- ◆ Нотолгооны тайланд ГТЭ-ийн хэрэгжүүлсэн нотолгооны үйл ажиллагаа болон нотолгооны дүгнэлтийн талаар тоймлоно.

◆ Ерөнхий шаардлагууд:

☞ Дараах асуудлуудыг үнэлэхэд нотолгооны үйл ажиллагаа чиглэнэ:

- (a) Хэрэгжсэн төслийн ашигласан аргазүйд тусгасан шаардлагуудыг хангалттайгаар биелүүлсэн;
- (b) Мониторингийн тайланд багтсан тоон мэдээ нь баталгаатай, үнэмшилтэй байх;
- (c) Давхар бүртгэлээс зайлсхийсэн байх;
- (d) Ашигласан аргазүйг ашиглахаас сэргийлж бүртгэлийн дараах өөрчлөлтийг зөвшөөрөхгүй.

☞ ГТЭ-ийн хянах үйл явц:

- (a) Бүртгэгдсэн ТББ-ийн батлагдсан өөрчлөлтүүд болон холбогдох магадлагааны үр дүнг багтаасан бүртгэгдсэн ТББ;
- (b) Холбогдох магадлагааны үр дүн болон магадлагаа нотолгоо нь зэрэг хийгдсэн бол магадлагаа хийгдсэн ТББ;
- (c) Магадлагааны тайлан;
- (d) Хэрэв бий бол өмнөх нотолгооны тайлан;
- (e) Ашигласан аргазүй;
- (f) Ашигласан аргазүйн Мониторингийн тайлангийн хуудас ашигласан эсэхийг нотлох мониторингийн тайлан;
- (g) Төслийн хүлэмжийн хийн бууралттай холбоотой ямар нэг мэдээлэл, эшлэл ;
- (h) Давхар бүртгэлээс сэргийлсэн бичгээр үйлдсэн баталгаажуулалт.

☞ ГТЭ нь ТО-ийн мэдүүлсэн мэдээлэлд үнэлгээ хийх бөгөөд дан ганц бичиг цаасан дээр суурилсан шүүмж бус газар дээр очиж танилцах үйл ажиллагааг багтааж МН-ны журамд заасны дагуу нотолгооны ажлыг гүйцэтгэнэ. Нотолгооны онцгой арга ажиллагаа шаардаагүй үед ГТЭ нь тохирох аудитын арга ажиллагааг ашиглана.

◆ Ашигласан аргазүйн тавигдах шаардлагууд болон төслийн хэрэгжилтийн нийцэл

ГТЭ ашигласан аргазүйн тавигдах шаардлагууд болон төслийн бодит байдлын уялдааг шалгана.


- ◆ Бүртгэгдсэн ТББ эсвэл шинэчилж баталсан ТББ-тай төслийн хэрэгжилтийг харьцуулан үнэлгээ хийх. ГТЭ нь бүртгэгдсэн ТББ, магадлуулсан ТББ эсвэл шинэчилж батлуулсан ТББ-тэй хамт бодит төслийг түүний үйл ажиллагааны хамт үнэлнэ.
- ◆ Холбогдох шаардлагуудад зааснаар хэмжсэн үр дүнг зөв болгох болон калибраци хийх давтамжийн нийцэл. Хэрэв төслийн ХүХ-н ялгаралын бууралттай холбогдох параметрууд нь хэмжих төхөөрөмжөөр хэмжигдсэн бол (ТББ болон Мониторингийн журамд заасан Мониторингийн сонголт) ГТЭ нь мониторингийн төлөвлөгөөний дагуу хэмжих төхөөрөмж нь зааврын дагуу калибраци хийгдэж явсан эсэх, мөн ТББ болон Мониторингийн журмын дагуу хэмжсэн тоон мэдээг шаардлагатай үед засч зөв болгосон эсэхийг тогтооно.
- ◆ ХүХ-н ялгаралын тоон мэдээ, тооцооллын үнэлгээ. ГТЭ нь батлагдсан аргазүйг ашиглан гаргасан төслийн ХүХ-н ялгаралын бууралтын тоон мэдээ, тооцооллыг үнэлнэ.
- ◆ Давхар бүртгэлээс сэргийлэх үнэлгээ. ГТЭ нь тухайн төсөл өөр олон улсын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах механизмд бүртгэлгүй эсэхийг нягтлан тогтооно.
- ◆ Бүртгэлийн дараах өөрчлөлт. ГТЭ нь ашигласан аргазүйн ашиглалтаас сэргийлэн бүртгэгдсэн ТББ эсвэл аргазүйгээс хойш ямар нэгэн өөрчлөлт гарсан эсэхийг тогтооно.

☞ Баталгааны түвшин: ГТЭ нь ISO 14064-3:2006-д зааснаар нотолгоондоо боломжит баталгааг өгнө.

☞ Бодит байдал: ГТЭ нь нотолгоондоо ISO 14064-3:2006-ны дагуу бодит байдлыг тусгана. Нотолгооны бодит байдлын үнэлэмж нь ялгаралын бууралтын 5%-ийг тогтооно.

8-2. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайланд үнэлгээ хийх


[GL SDCP/CR ver01.0], [GL PCP ver06.0, para 69-80]



6-3. Кредит олгох хүсэлт гаргах журам

8-3. Кредит олгох талаар хүсэлт гаргах үйл явц

[PCP ver.6, para 81-91, 144-148]



Тайлбар: Кредит хуваах [PCP ver.6, para 81-82]
ТО талууд хоорондоо зөвлөлдөж, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах буюу шингээлтэнд оруулах хувь нэмрийг нь харгалзан авч үзэн кредитийг хуваана. ТО тал нь кредитээ Монгол / Японы талд хувааж тооцуулж болно.

XX-ны кредит олгох шийдвэр
(5) ХХ тал тус бүрт олгох кредитийн хэмжээг мэдэгдэнэ.

Монгол/Японы Засгийн Газар
2 талаас кредит олгох үйл явц
(7) Нарийн бичгийн газраас мэдэгдмэгц талууд ТО-оос тодорхойлсон кредитийн хэмжээний дагуу кредитийг олгох бөгөөд энэ тухай нарийн бичгийн газраар дамжуулан ХХ-нд мэдэгдэнэ.

9-1. Нэрээ эргүүлэн татах хүсэлт гаргах үйл явц

[PCP ver.6, para149-154]

Төсөлд оролцогч талууд

Нарийн бичгийн газар

- (1) Доор дурдсан тохиолдолд ТО нь бүрэн гүйцэд хүсэлт гаргасан мэдүүлгийн маягтыг хамгийн сүүлийн хувилбарыг ашиглан ХХ-д цахим хэлбэрээр гаргах үүрэгтэй:
- a) Төсөлд оролцогч нь бүртгэгдсэн эсвэл бүртгүүлэхээр хүсэлт гаргасан ХКОМ-ын төслөөс сайн дураар нэрээ эргүүлэн татаж болно.
- ☞ Төсөлд оролцогч нь “ХКОМ-ын төслөөс нэрээ эргүүлэн татах хүсэлт гаргах маягт”-ийг бүрэн гүйцэд бөглөн хүсэлт гаргах
- (b) (i) Төсөлд оролцогч нь бүртгүүлэхээс татгалзах хүсэлтийг сайн дураар гаргах
- (ii) ГТЭ нь шинэ мэдээлэл, ажиглалт дээр үндэслэн магадлагааны байр сууриа өөрчилж энэ талаар төсөлд оролцогч талд мэдэгдсэн бол
- ☞ Төсөлд оролцогч нь “ХКОМ-ын бүртгэх хүсэлтээс нэрээ татах маягт”-ийг бүрэн гүйцэд бөглөн мэдүүлэх
- (c) (i) Төсөлд оролцогч нь олгосон тодорхой заагдсан мониторинг хийх хугацаанаас нэрээ сайн дураар эргүүлэн татах
- (ii) ГТЭ нь Нотолгооны тайлангаа шинэ ажиглалт дээр үндэслэн шинэчилж төсөлд оролцогчид үүнийгээ мэдэгдсэн бол
- ☞ Төсөлд оролцогч нь бүрэн гүйцэд бөглөсөн “ХКОМ-ын эрх олгох хүсэлтээс нэрээ эргүүлэн татах маягт”-ийг мэдүүлэх
 - ☞ Бүх хүсэлтийн маягтын өмнөх хувилбарыг шинэ маягт гарснаас хойш 6 сарын дотор ашиглан илгээж болно.

- (2) Нэрээ эргүүлэн татах хүсэлтийг хүлээн авсан даруйд нарийн бичгийн газар нь баримт бичгүүдийн мэдүүлгийг хүлээн авсныг баталгаажуулна.

- (3) Нарийн бичгийн газар баталгаажуулснаар:
- (a) Төсөл нэрээ эргүүлэн татахад ХКОМ-ын цахим хуудас дээр тухайн төслийн “нэрээ эргүүлэн татсан” гэж тэмдэглэнэ;
 - (b) Бүртгүүлэх үйл явцаас нэрээ эргүүлэн татах хүсэлт гаргахад ХКОМ-ын цахим хуудас дээр бүртгэлийн хүсэлтийг “нэрээ эргүүлэн татсан” хэмээн тэмдэглэнэ;
 - (c) Олгосон хугацаанаас нэрээ эргүүлэн татах хүсэлт гаргахад ХКОМ-ын цахим хуудас дээр мониторинг хийхээр олгосон тодорхой хугацааг “нэрээ эргүүлэн татсан” хэмээн тэмдэглэнэ.

ТАЙЛБАР

Энэ бичиг баримтад ашиглагдсан товчилсон үгсийн тайлбар нь холбогдох албан бичиг баримтын нэр, томъёонууд болно

[] хашилтад орсон товчилсон нэрсийн тайлбар	Хамаарах албан баримт бичгийн нэрс болон ялгах тэмдгүүд
Doc., para1	“Монгол, Япон улсын Засгийн Газар хооронд байгуулсан “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” байгуулах Хоёр талт хамтын ажиллагааны баримт бичиг”, догол мөр 1
GOJ Oct 2018	Япон улсын Засгийн газар “ Хамтарсан Кредит Олгох Механизмын хэрэгжилтийн явц” 2017 оны 7-р сар
RoI ver.4, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмыг Хэрэгжүүлэх дүрмүүд (ХКОМ) 4.0 дугаар хувилбар,1-р догол мөр (2018 оны 11-р сарын 6-нд хувилбар.4 нь батлагдсан.)
Glos ver.1, No. 1	Хамтарсан Кредит Олгох Механизмын нэр томъёоны тайлбар. Хувилбар 1, No.1 (2013 оны 5-р сарын 23-нд хувилбар.1 батлагдсан.)
PCP ver.6, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Төслийн үйл явц Хувилбар 6.0, догол мөр 1 (2018 оны 11-р сарын 6-нд хувилбар.6 батлагдсан.)
GL PM ver.2, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Санал болгосон аргазүйыг боловсруулах журам Хувилбар 2.0, догол мөр 1 (2016 оны 7-р сарын 30-нд хувилбар.2 батлагдсан.)
GL PDD ver.3.1, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Төслийн Баримт Бичиг боловсруулах журам Хувилбар 3.1, догол мөр 1 (2017 оны 10-р сарын 24-нд хувилбар.3.1 батлагдсан.)
GL SDCP/CR ver.1, para 1	Хамтарсан Кредит Олгох Механизмын төслийн Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайлан боловсруулах журам Хувилбар 1 (2018 оны 11-р сарын 6-нд хувилбар.1 батлагдсан.)
GL TPE ver.4, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Гуравдагч Хөндлөнгийн Байгууллагыг томилох журам Хувилбар 4.0, догол мөр 1 (2016 оны 7-р сарын 30-нд хувилбар.4 батлагдсан.)
GL VV ver.1, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Магадлагаа, Нотолгооны журам Хувилбар 1.0, догол мөр (2013 оны 5-р сарын 23-нд хувилбар.1 батлагдсан.)
RoP ver.2, para1	Хамтарсан Кредит Олгох Механизмын Хамтарсан Хорооны үйл явцын дүрэм журам Хувилбар 2.0, догол мөр 1 (2015 оны 4-р сарын 5-нд хувилбар.2 батлагдсан.)
Anx stands for Annex, Apx for Appendix, Att for Attachment, and Ann for Annotation.	

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТУУД

АСУУЛТ	ХАРИУЛТ
ХКОМ-ын санхүүгийн дэмжлэгийг хэн авах эрхтэй вэ?	Төслийн саналаа Япон талын аж ахуйн нэгж болон Монгол талын аж ахуйн нэгжийн хамтран байгуулсан олон улсын консорциумыг төлөөлөн Япон талын аж ахуйн нэгж байгууллага нь илгээнэ.
Ямар төрлийн төсөл ХКОМ-ын төсөл болон хэрэгжих боломжтой вэ?	Дэвшилтэт технологийг ашиглан нүүрсхүчлийн хий, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулж болох төслүүдийг санал болгох боломжтой. Бүртгэгдсэн төслүүдэд ашиглаж буй технологиуд нь нам даралтын зуух, нарны эрчим хүчний үүсгүүр, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг (LED), тоон хурд хэмжигч (тээврийн хэрэгсэлийн), үйлдвэр, барилга байгууламж болон бусад салбаруудад эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн суурилуулалт зэрэг байна. Дараах линкээр орон ХКОМ-ын хүрээнд ямар төрлийн төслүүд батлагдан хэрэгжиж байгааг харах боломжтой. http://gec.jp/jcm/projects/index.html
Төсөлд оролцогч талд ХКОМ-ын аргачлалыг боловсруулахад үзүүлэх дэмжлэг юу байх вэ?	ХКОМ-ын санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу ХКОМ-ын төслийн аргазүй, аргачлалыг боловсруулахад зөвлөх байгууллагаас дэмжлэг авах боломжтой. Энэ тохиолдолд, төсөлд оролцогч тал аргачлалыг боловсруулах мэдээллээр зөвлөх байгууллагыг хангах ба бие даан аргачлалыг боловсруулах шаардлагагүй болно.
Манай байгууллагад Япон талын түнш байхгүй. Япон талын хамтран ажиллах түнштэй болоход хаанаас туслалцаа авах вэ?	Энэ асуудлаар Монгол дах ХКОМ-ын нарийн бичгийн газартай (БОАЖЯ-ны харьяа Байгаль Орчин, Уур Амьсгалын сан) холбогдох, эсвэл Хилийн чанад дах Байгаль орчны хамтын ажиллагааны төв зэрэг байгууллагуудтай холбогдож болно. (info@carbon-markets.go.jp)
ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх хүсэлтээ илгээснээс хойш ХКОМ-ын төслөөр бүртгэгдэх хүртэл хир хугацаа орох вэ?	Төсөл бүрийн хугацаа өөр байх ба ХКОМ-ыг бодит, энгийн механизм болгохыг зорьж байна. ХКОМ-ын хүрээнд алыан ёсоор бүртгэгдсэн 40 төслийн жишгээс харахад бүртгүүлэх хүсэлтээ гаргаснаас хойш 70 хоногийн дотор бүртгэгдсэн байна.
ХКОМ-ын төсөлд тооцогдсон кредитийг хэрхэн хуваарилах вэ? Тооцуулсан кредитээ худалдаалж болох уу?	ХКОМ-ын кредитийн хэмжээг төсөлд оролцогч тал/ эсвэл Засгийн газарт тал тус бүрийн Хүлэмжийн хийн ялагаралын бууралт, шингээлтэд оруулсан хувь нэмэрт үндэслэн тооцно. Тухайн төсөлд тооцох кредитийн тодорхой хэсгийг Монгол улсын Засгийн газар, Японы Засгийн газарт хуваарилан тооцож болно. Монгол улсад бүртгэгдсэн ХКОМ-ын кредит нь Монгол улсын баримталж буй бодлогын хүрээнд зохицуулагдах ба Япон улсад бүртгэгдсэн кредитийг Япон улс дотроо худалдаалах, ашиглах бүрэн боломжтой байгаа



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН
УУР АМЬСГАЛЫН САН

Байгаль Орчин, Уур Амьсгалын сан,
Байгаль орчин, Аялал Жуулчлалын яам
7 давхар, 22 дугаар байр,
Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс
Э-Шуудан: jcmmongolia@gmail.com
Цахим хуудас: www.jcm-mongolia.com



Зах зээлийн механизмуудын алба
Уур амьсгалын өөрчлөлтийн
бодлогын хэлтэс,
Даян Дэлхийн Байгаль Орчны Товчоо,
Япон улсын Байгаль орчны яам
1-2-2, Касүмигасэки, Чиёода-кү,
Токио хот, 100-8975 Япон,
Цахим хуудас: <http://www.env.go.jp/>



Climate and Energy Area
Institute for Global Environmental Strategies
2108-11, Kamiyamaguchi, Hayama,
Kanagawa, 240-0115 Japan
EMAIL: ce-info@iges.or.jp
<http://www.iges.or.jp/en/climate-energy/index.html>

© Япон улсын Байгаль орчны яам, 2018.

Энэхүү тоймыг Япон улсын Байгаль орчны яамны дэмжлэгтэйгээр Монгол улс дахь Хамтарсан Кредит Олгох Механизмын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд зориулан Даян дэлхийн байгаль орчны стратеги судлалын хүрээлэн болон БОАЖЯ-ны харьяа Байгаль Орчин, Уур Амьсгалын сан нар хамтран гаргав.

Энэ товхимолд орсон бүх мэдээлэл нь хэвлэлтэнд өгөх үеийн байдлаар үнэн зөв гэж үзэх бөгөөд зохиогчийн зүгээс холбогдох алдаа эсвэл орхигдуулсан ямар нэг мэдээлэлд хуулийн хариуцлага хүлээхгүй.

Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлсэн: Л.Отгонцэцэг (Байгаль Орчин, Уур Амьсгалын сан)